



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-53

1.Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох, чөлөөлөх тухай асуудал	2-4
2.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/	5-53

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
05 дугаар сарын 08-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 73 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: М.Бадамсүрэн, Н.Батсүмбэрэл, Б.Батцэцэг, П.Батчимэг, Ж.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, С.Бямбацогт, С.Ганбаатар, Б.Дэлгэрсайхан, Б.Жавхлан, Б.Мөнхсоёл, Ч.Номин, Д.Пүрэвдаваа, Б.Пүрэвдорж, О.Саранчулуун, Б.Тулга, А.Ундраа, Д.Цогтбаатар, Б.Чойжилсүрэн, Д.Энхтуяа;

Чөлөөтэй: З.Мэндсайхан, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Амарсайхан, Х.Баттулга, Б.Түвшин, Д.Үүрийнтуяа;

Хоцорсон: Ц.Алтаншагай-13 минут, Ч.Анар-07 минут, Т.Аубакир-24 минут, Х.Баасанжаргал-01 минут, Б.Батбаатар-07 минут, Д.Батбаяр-15 минут, Ж.Баясгалан-02 минут, Б.Бейсен-21 минут, Х.Булгантуяа-02 минут, Г.Ганбаатар-04 минут, П.Ганзориг-03 минут, Л.Гантөмөр-27 минут, М.Ганхүлэг-06 минут, Ц.Даваасүрэн-06 минут, Ц.Даваасүрэн-06 минут, Т.Мөнхсайхан-02 минут, Ц.Мөнхтуяа-04 минут, П.Наранбаяр-22 минут, Н.Номтойбаяр-02 минут, Э.Одбаяр-16 минут, Б.Пунсалмаа-15 минут, М.Сарнай-03 минут, Н.Учрал-17 минут, Г.Уянгахишиг-36 минут, Б.Хэрлэн-01 минут, Ж.Энхбаяр-2 цаг 13 минут, С.Эрдэнэбат-36 минут, Р.Эрдэнэбүрэн-08 минут.

Нэг.Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох, чөлөөлөх тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалд нэр дэвшигч С.Магнайсүрэн оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111.2-т “Нэгдсэн хуралдаан эрх бүхий албан тушаалтны санал, холбогдох

Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож нууц санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх томилох, чөлөөлөх саналыг дэмжсэн бол энэ тухай тогтоол баталсанд тооцно.” гэж заасны дагуу хэлэлцэв.

Эрх бүхий албан тушаалтны саналыг Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, нэр дэвшигчийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням нар тус тус танилцуулав.

Эрх бүхий албан тушаалтны санал болон Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан нэр дэвшигчээс Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Да.Цогтбаатар, Н.Наранбаатар, Г.Лувсанжамц, Д.Ганбат, Ж.Алдаржавхлан, Ж.Галбадрах, Л.Мөнхбаатар, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалд нэр дэвшигч С.Магнайсүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, А.Ариунзаяа, Л.Энхнасан, Н.Наранбаатар, Б.Бат-Эрдэнэ, Ц.Идэрбат, П.Сайнзориг, О.Цогтгэрэл, Б.Уянга, Ч.Ундрэм, Г.Лувсанжамц нар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Сандагийн Магнайсүрэнг Монгол Улсын Ерөнхий аудитораар томилох саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75
Татгалзсан: 18
Бүгд: 93
80.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох санал дэмжигдсэн тул “Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Дэлэгийн Загджавыг Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 33
Бүгд: 93
64.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторыг чөлөөлөх санал дэмжигдсэн тул “Монгол Улсын Ерөнхий аудиторыг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох тухай”, “Монгол Улсын Ерөнхий аудиторыг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолуудын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолуудын эцсийн найруулгатай танилцлаа./11:39/

Уг асуудлыг 11 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндсэн хуулийн цэцийн гишүүн Б.Болдбаатар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Б.Болдбаатар, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа нар тус тус танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Д.Бум-Очир, А.Ганбаатар, С.Зулпхар, О.Номинчимэг, Д.Энхтүвшин, Л.Мөнхбаатар, Ц.Даваасүрэн, Х.Баасанжаргал, Б.Найдалаа нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./12:46/

Уг асуудлыг 12 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 2 цаг 47 минут үргэлжилж, 126 гишүүнээс 100 гишүүн хүрэлцэн ирж, 79.4 хувийн ирцтэйгээр 12 цаг 47 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая 68 гишүүн ирцэд бүртгэгдэж, ирц 54 хувьтай болсон байна 2025 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн нэгдсэн хуралдаан эхэлснийг мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдөр 2 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Монгол Улсын ерөнхий аудиторыг томилох чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Хоёрдугаарт, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалд оръё. Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ. Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох тухай саналыг уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Д.Амарбаясгалан: Төрийн албаны тухай, Төрийн аудитын тухай хуульд заасан нийтлэг болон тусгай шаардлагыг хангаж байгаа Сандагийн Магнайсүрэнг Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж байна аа. Сандагийн Магнайсүрэн 1975 онд төрсөн, 50 настай 1983-аас 1993 онд Говь-Алтай аймгийн төвийн 1 дүгээр 10 жилийн дунд сургууль, 1993-аас 1997 онд МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн. Хууль зүйн шинжлэх ухааны магистр зэрэгтэй. Ажилласан байдал 1997-оос 1999 онд Улаанбаатар эрдэм дээд сургуульд багш, тэнхимийн эрхлэгч, 1999-өөс 2000 онд Улсын Их Хурлын Тамгын газарт Улсын Их Хурлын гишүүний туслах, 2000-2005 онд Улсын Их Хурлын Тамгын газарт зөвлөх, 2005-аас 2006 онд СБД-ийн ЗДТГ-ын Тамгын газрын дарга, 2006-аас 2007 онд Хүнс, хөдөө аж ахуйн яаманд яам сайдын зөвлөх, 2007-оос 2008 онд Сангийн яаманд газрын дарга, 2008-аас 2013 онд Улсын Их Хурлын Тамгын газарт Тамгын газрын нарийн бичгийн дарга 2015 онд Хөдөлмөрийн яаманд ТНБД, 2015-аас 2023 онд Барилга, хот байгуулалтын яаманд ТНБД, 2023-аас 2024 онд Уул уурхайн яамны ТНБД-аар тус тус ажиллаж байсан.

Эрхэлсэн түшмэлээс дээш ангиллын албан тушаалд буюу тэргүүн түшмэлийн албан тушаалд 12 жил 5 сар ажилласан. Түүнчлэн Япон улсын хамтын ажиллагааны байгууллагад хоршооны хөгжлийн чиглэлээр, БНАУ-ын ОУВС-д Төв банк санхүүгийн чиглэлээр, БНСУ-ын хамтын ажиллагааны агентлагт цахим архивын чиглэлээр, АНУ-ын Орт коллежид англи хэл, БНЭУ-ын Төрийн удирдлагын

академид төрийн захиргааны чиглэлээр тус тус мэргэшүүлэх сургалтад хамрагдаж байсан.

Төрийн аудитын тухай хуулийн 28.2-т заасан 45 насанд хүрсэн, эдийн засаг, санхүү, эсхүл хууль зүйн чиглэлээр дээд боловсролын зэрэгтэй байх, төрийн албаны эрхэлсэн түшмэлээс дээш ангиллын албан тушаалд 10-аас доошгүй жил ажилласан байх, сүүлийн 6 жилийн хугацаанд улс төрийн намын гишүүнчлэлгүй, улс төрийн идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй байх, харшлах ажил, албан тушаал давхар эрхэлдэггүй, аж ахуйн нэгж мэргэжлийн болон ТББ-д ашиг сонирхлын зөрчилгүй байх шаардлагыг хангаж байна гэж үзэж Сандагийн Магнайсүрэнг Монгол Улсын ерөнхий аудитораар томилуулахаар нэр дэвшүүлж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Ингээд нэр дэвшигчийн талаар гаргасан Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням танилцуулна аа.

Индэрт урьж байна.

Г.Дамдинням: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төсвийн байнгын хороо 2025 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын ерөнхий аудиторовын албан тушаалд нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хур хуралдаанд танилцуулж байна аа.

Монгол Улсын Их Хурлын даргаас Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28-ны 1 дэх хэсгийг үндэслэн Монгол улсын ерөнхий аудиторовын албан тушаал Сандагийн Магнайсүрэнг Улсын Их Хуралд санал болгосон. Төсвийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторовын албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголыг зохион байгуулахтай холбогдуулан дараах ажиллагааг явуулсан болно.

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйл.

Мөн хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1, 131.2 дахь хэсэгт заасны дагуу Төсвийн байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 08 дугаар тогтоолоор нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 5 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулахаар товлож, 14 хоногийн хугацаанд сонсголд оролцогчдыг бүртгэх болон нэр дэвшигчийн талаарх саналыг хүлээн авахаар сонсголын зарыг олон нийтэд хүргэсэн.

2.Монгол Улсын ерөнхий аудиторовын албан тушаалд нэр дэвшигчийн сонсголыг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням даргалж, сонсголд Төсвийн байнгын хорооны гишүүд нэр дэвшигч С.Магнайсүрэн болон зарын дагуу бүртгүүлсэн 4 оролцогч нэг ажиглагч эргэн оролцлоо.

3.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1 дэх хэсэгт заасны дагуу нэр дэвшигчийн сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар нэр дэвшигч С.Магнайсүрэнг тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан гэж үзсэн байна аа.

Нэр дэвшигчийн сонсголын тайланг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулан Улсын Их Хурлын дарга болон нийт гишүүд, нэр дэвшигчдэд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно. Төсвийн байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын ерөнхий аудитораар Сандагийн Магнайсүрэнг томилж, бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсонтой холбогдуулан Дэлэгийн Загджавыг Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас нь чөлөөлөхийг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжлээ.

Монгол Улсын ерөнхий аудиторын албан тушаалд нэр дэвшигчийн танилцуулга, нэр дэвшигчийн сонсголын тайлан болон Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ерөнхий аудиторт нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Сандагийн Магнайсүрэн хүрэлцэн ирсэн байна.

Эрх бүхий албан тушаалтны санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье өө. 19 гишүүнээр тасаллаа. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууж, үг хэлье.

Г.Тэмүүлэн: Монгол Улс бол парламентын засаглалтай. Тэгэхээр төрийн эрх барих дээд байгууллага буюу Улсын Их Хурлын энэ Улсын Их Хурлын хяналт тавих эрх хэрэгжүүлэхэд бол аудитын байгууллага үндсэн гол үүрэгтэй. Үндсэндээ бол бид бүхэн энэ төрийн санхүү болоод төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэхэд үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд бол аудитын байгууллага хараат бусаар ажиллаж, мэргэжлийн дүгнэлтийг гаргаж энэ үйл ажиллагааны үр өгөөж ил тод байдлыг дээшлүүлэхэд бол дотоод хяналт шалгалтыг нь сайжруулахад дэмжлэг үзүүлж ажиллах ёстой байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол би шинэ удирдлагыг бол мэргэжлийн хүн орж ирж байна. Нэлээн хариуцлагатай ажиллах байх гэж бол итгэж найдаж байгаа, 1 дүгээрт хэлчихье.

Хоёрдугаарт Засгийн газраас шинэ удирдлага бол хараат бусаар ажиллах ёстой шүү. Тэр дундаа энэ Сангийн яамнаас, сайдуудаас төсвийн ерөнхийлөн захирагч нараас би энэ дээр онцгойлж хэлэх гээд байгаа зүйл бол үндсэндээ одоо ингээд төсвийн гүйцэтгэл орж ирэх гэж байна. Магадгүй төсвийн тодотгол үндсэндээ яригдах ёстой. Энэ асуудал болгон дээр мэргэжлийн өнцгөөр хандах ёстой. Би энэ

дээр нэг зүйлийг онцолж хэлэхгүй бол болохгүй болчхоод байна аа. Энэ шинэ аудитын удирдлагаар нэр дэвшиж орж ирж байгаа хүн ч гэсэн анхаарах нь зүйтэй байх. Ер нь бол энэ их онигоотой зүйл болж байна аа. Гишүүд ч гэсэн анхааралтай байгаарай. Энэ өөрөө юу юм бэ гэхээр энэ би хараад байгаа нь гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай гэсэн энэ хуулийн төслийг үндсэндээ Сангийн яам бол хүмүүсийн гараар гар бариулж энэ хуулийн төслийг хийсэн байна.

Гишүүд энийг өргөн барих гэж байгаа юм шиг 40 орчим гишүүдээр гарын үсэг зуруулсан байна аа. Төсвийнхөө өр зээлийг төсвийнхөө гадна гаргах энэ хуулийн төслийг бол хийж байгаа юм байна аа. Бид нар тэр гадаад зээлийг хэчнээн ямар нэрээр ч нэрлэсэн өөрсдийгөө хэчнээн хуурсан ч эцсийн эцэстээ бол бид нар энэ өр зээлийг бол төлөх энэ нөхцөл байдал дээр л үүснэ ээ.

Тэгэхээр 1-д би гишүүд бол гишүүдийн гараар энэ юу гэдэг юм мэдэхгүйгээр нь далимдуулж, шинээр нь далимдуулж энэ хуулийн төслийг оруулж байгаа энэ оролдлогоо бол Сангийн яамыг боль гэж хэлэх гээд байгаа юм. Бараг 40 гаран гишүүдээр зуруулсан гэж яригдаж байгаа. Одоо би магадгүй Сангийн яам бол энэ хуулийнхаа хулгайн дээр бол мэргэшиж байна гэж харж байгаа. 2024 оны төсвийн тодотголыг яг ийм байдлаар хийсэн. Төсвийн суурь тэнцэл гэдэг зүйлийг гаргаж ирсэн. Одоо 2025 оны төсөвт тодотгол хийх аргаа бол яг энэ аргаараа хийж байна. Хуулийн хулгайгаар. Үндсэндээ 2025 оны төсөвт бол 3 дахь удаагаа гар хүрч байна. 3 дахь удаагаа тодотгол хийх ёстой суурь зарчмын асуудлыг бол хуулийн хулгайгаар хийж байгаа энэ асуудал байна аа.

Тэгэхээр та нар энэ асуудалд энэ зөв асуудлаар нь өнцгөөр нь ханд. Зарчмынх нь тухай асуудлыг хий. Тодотголыг нь оруулж ир. Магадгүй би зүгээр буруу нэг жишээ хэлэх гэж байна. Магадгүй 10 орчим жилийн өмнө та бүхэн мэдэж байгаа байх. Өрийг өглөг гэдэг үгээр солих нэг саналыг нэг гишүүн гаргаж байсан юм. Энэнээс бол би долоо дор зүйл болж байна гэж харж байгаа.

Мянга бид нар тэр хуулийнх нь нэр томьёог нь өөрчилсөн ч зээлээ эргүүлээд төлнө. Яг Сангийн яамныхны энэ тэнэглэлээр бол Монгол Улсын өртэй айл болгон өр зээлээ өрхийнхөө данснаасаа хасаад өр зээлгүй юм шиг нүдээ аниад ингээд хэсэг явах юм байна л даа. Тэгээд улс орноороо, айл өрхөөр ингээд дампууралд орох юм байна. Ийм юу гэдэг юм ийм зүйлийг бол үндсэндээ би хийж болохгүй. Энэ чинь эдийн засгийн нөхцөл байдлыг бид нар агуулгаар нь суурь шалтгааныг нь бол засаж залруулах ёстой байгаад байгаа. Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд өөрсдөө муудчихсан байна. Энийг бид нар засах ёстой байгаад байгаа. Төсөв санхүү өөрөө хүндэрлээ. Эдийн засаг ард түмний амьдрал өөрөө жоохон хүндхэн байна. Тэгэхээр бол би Сангийн яаманд хэлж байгаа зүйл бол ийм тэнэглэлээр улсын төсөвт эдийн засагт бол хандахаа болио. Энэ улс орон чинь бол хууль дүрэм, журамтай, төсөв санхүү энэ бодлоготой. Энэ эдийн засгийн онол зарчим гэж зүйл байдаг. Тэрнийх нь дагуу бол хийх зайлшгүй шаардлага байгаад байгаа юм. Тэрнээс одоо бол хуулийн хулгайгаар энэ төсвийн тодотголыг хийнэ гэсэн зүйл бол байж болохгүй шүү. Энэ гадаадын зээлийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх тухай гээд яг үндсэн агуулгынхаа эсрэг буюу төсвийнхөө зээлийг.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууж, үг хэлье.

А.Ариунзаяа: Монгол Улсад хүүхдийн байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойн баярын мэндийг энэ дашрам та бүхэндээ хүргэе ээ. Хүүхдийн өмнө хүн бүр насанд хүрсэн хүн бүр үүрэг хүлээж байгаа. Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3-аар байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлоготой байх ёстой гэдэг хуулийг баталсан. Тэгээд энэн дээр бол Магнайсүрэн дарга, ТНБД байхдаа маш манлайлан ажиллаж тухайн яамныхаа бодлогод хүүхэд хамгааллын бодлогыг тусгаж хүүхэд хамгааллын эцэг эхийн зөвлөл байгуулж тухайн цалингийн сангийн хүүхэд хамгааллын зардлыг хүртэл тусгаж үлгэрлэн манлайлсан. Тэгээд яг энэ аудитын даргаар хэрэвзээ сонгогдвол хуулиар хүлээсэн үүргийг төрийн байгууллагууд өөрсдөө биелүүлдэг байх тал дээр анхаарч өгнө үү гэсэн ийм захиасыг хэлж байна аа.

Хүүхэд хамгааллын тухай хуулиар байгууллага өмчийн хэлбэр үл хамаараад цалингийн сангийн нэг хүртэл, нэг хувиар хүүхэд хамгааллын зардалд тусгаж зарцуулна. Тухайн байгууллагын ажилчдын хүүхдүүдэд зориулсан хөгжил хамгааллын бодлого явуулна гэснийг заасан байгаа. Тэгэхээр бүхнийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ч юм уу хүүхдийн газар бол зохицуулж чадахгүй. Ийм учраас хуулиар байгууллага бүрд энэ үүргийг хүлээлгэсэн байгаа юм аа. Тэгэхээр төр өөрөө хуулийг баталж байгаа юм бол өөрөө үүнийг бас хариуцаж биелүүлдэг байх ёстой гэдэг ийм захиасыг хэлж байгаа юм.

Хоёр дахь нь болохлоор өнгөрсөн төсвийн хэлэлцүүлгийн үеэр би бас санал гаргаж мөн адил Ахмадын хөгжлийн тухай хуулийн дагуу төр хүлээсэн үүргээ биелүүлж төрийн байгууллагууд цалингийн сангийн 3 хүртэл хувиар ахмадын сан байгуулах үүргээ хэрэгжүүлээч. 2017 онд энэхүү хууль батлагдсан. Түүнээс хойш төр өөрөө биелүүлэхгүй байгаа учраас хувийн хэвшил ч гэсэн үүнд хойрго хандаж байна гэдэг ийм асуудлыг дэвшүүлээд нийцлийн аудитын сэдвийн захиалга доор бол яг энэ ахмадын санг төрийн байгууллагууд байгуулж уу үгүй юу гэдгийг хянаж шалгаж өгөөч гэдэг ийм хүсэлтийг гаргасан. Тэгээд сэдэв нь бол батлагдсан байгаа. Тэгээд та хэрэвзээ сонгогдох юм бол ахмадын сан байгуулсан эсэх, эргүүлээд мөн Хүүхдийн сан байгуулагдаж байгаа эсэх дээр хараа хяналт тавьж өгч төр өөрөө энэ баталсан хуулиудаа хэрэгжүүлдэг байх тал дээр нь анхаарч өгөөсэй гэж хүсэж байна аа. Ер нь бол ахмадуудын манай Монгол Улс хөдөлмөр эрхлэлт дээр хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах хүчний хомсдолд орсон байгаа гэдгийг бол бүгдээрээ л ярьж байгаа. Тэгээд үүн дээрээ бол ахмадын хөдөлмөр эрхлэлтийг хамгаалах чиглэлээр Хөдөлмөрийн тухай хууль ч гэсэн батлагдсан. Ажил олгогчийн санаачилгаар тэтгэвэрт нь гаргах энэ боломж байхгүй. Зөвхөн ажилтан өөрөө хүсэх юм бол тэтгэврээ тогтоолгох эрх нь үүсэж байгаа. Мөн түүнчлэн 50-аас дээш ажилтантай ААН байгууллагууд бүгд ажиллагсдын 2 хувьд ахмадыг ажиллуулах үүргийг мөн хуулиар хүлээсэн байгаа. Ингэснээрээ бас хуулийг төрийн байгууллагууд өөрсдөө бас хариуцдаг байх хэрэгтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг 25-аас дээш ажилтантай аж ахуйн нэгж байгууллага мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах үүргийг хүлээж байгаа. Тэгэхээр энэн дээр ч гэсэн төрийн байгууллагууд 25-аас дээш ажилтантай бол хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулж байгаа эсэх ажиллуулаагүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэмцэх тэтгэмжийг гэдэг юм уу төлбөр хураамжийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлдэг ийм хуультай.

Тэгэхээр эдгээр асуудлууд дээр төрийн байгууллагууд бодлого шийдвэрийг дагаж байна уу үгүй юу гэдэг дээр аудитын байгууллага энэ аудитаа хийхдээ

нийцлийн аудитын сэдэв батлагдсан эсэхээс үл хамааран анхаарч байхыг хүсье ээ. Таныг бол дэмжиж байна аа. Мэргэжлийн, төрд маш олон жил ажилласан хараат бус мэргэжлийн ийм хүн байгаа юм. Дэмжиж үг хэллээ.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Лутаагийн Энхнасан гишүүн асуулт асууж, үг хэлье.

Л.Энхнасан: Гишүүдийн өглөөний амар амгаланг айлтгая. Магнайсүрэн дарга та төрийн хяналтын хамгийн хариуцлагатай албанд нэр дэвшиж байна. Амжилт хүсье. Дэмжиж байна.

Дараах нэг хэдэн захиасыг хүргэхийг хүсэж байна. Эрүүл мэндийн, нийгмийн даатгалын сангууд бол ард иргэдийн эрүүл мэнд, ажиллах чадвар, тэтгэвэр, хөдөлмөрийн баталгааг хангасан энэ үндсэн багана байгаа юм. Тиймээс эдгээр сангийн мөнгөний зарцуулалтыг бол үр ашигтай ил тод байдал дээр онцгой анхаарч ажиллана уу гэж хүсэж байна аа. Эдгээр сангийн хөрөнгө бол ард түмний цалингаас хуримтлагдаж байгаа. Тиймээс нэг ч төгрөг үр ашиггүй зориулалтын бусаар зарцуулагдах бол олохгүй гэж бодож байна аа. Ийм болохлоор нийгмийн даатгалын сангийн тэтгэвэр, тэтгэмжийн тогтолцооны тогтвортой байдал эрүүл, мэндийн сангийн алдагдлын шалтгаан, хуулийн хэрэгжилт, дотоод хяналт, хөндлөнгийн нөлөөлөл зэрэг нарийн үнэлгээг бол хийж ажиллахыг хүсэж байна аа. Мөн аудит хийхдээ зөвхөн алдаа хайх биш зөв зам руу чиглүүлэн засаглалын гол хэрэгсэл гэж би итгэж байгаа.

Тийм болохлоор энийг санаж төрийн нэрийн өмнөөс шударга мэргэжлийн байр суурьтай ажиллана гэж хүсэж байна аа. Ингээд Магнайсүрэн даргад амжилт хүсье, дэмжиж байна.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууж үг хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Нэр дэвшигчид амжилт хүсье ээ. Тэгээд 3 яамны манай Монгол Улсын 3 том яамны ТНБД-аар ажиллаж байсан ийм туршлагатай хүн орж ирж байгаад л баяртай байна. Яах вэ аудитын асуудал дээр жил болгон л дүгнэлт гардаг. Хэрэгжихгүй байгаатай л холбоотой асуудлууд байгаад байгаа юм. Тэгэхээр яагаад хэрэгжихгүй байгаа вэ гэдэг дээр их сайн анализ дүгнэлтүүд хийх ёстой байна. Аудитын байгууллага хатуу арга хэмжээ авахгүй байгаад байгаа учраас дараа жил энэ алдаа дутагдал давтагдаж байгаа. Давтагдаад байгаа учраас Монгол Улсын сан хөмрөг, тогтолцоо, санхүү, эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой асуудлууд үргэлжилсээр л байгаа. Нөгөө хуулийн хулгай гэдэгтэй адилхан хулгай үргэлжилсээр л байгаа. Энэ сангуудын холбоотой асуудлууд аудитын байгууллага хатуу үр дүн хатуу арга хэмжээ авч явж байсан бол сангуудтай холбоотой энэ асуудлууд бол тухайн үедээ зогсчих боломж байсан болов уу гэж харж байгаа.

Дээрээс нь төрийн захиргааны байгууллагуудын асуудал байна. Өнөөдөр хязгаарлалттай сөрөг дүгнэлт гарах боломжгүй гээд дүгнэлтүүд нь гараад байдаг. Гэтэл тэрэн дээр ямарваа нэг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь яг ний нуугүй хэлэхэд бодит үр дүнд хүрч байгаа зүйлсүүд нэг талдаа байхгүй.

Тэгэхээр энэ дээр та маш хатуу байр суурь барьж ажиллаарай. 3 яам, Хөдөлмөрийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн

яам, ТНБД-аар та ажиллаж байсан. Энэ 3 яамтай холбоотой асуудлууд мөн ялгаагүй л орж ирнэ. Тэгээд энэ дээр бол хараат бус зарчмаа төрийн ноён нуруу гаргаж өнөөдрийг хүртэл ажиллаж ирсэн учраас гаргаж ажиллана гэдэгт итгэж байгаа. Тэгээд танд аминчлан захих ганц зүйл бол энэ аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой асуудал дээр тодорхой үр дүнг хүргэж гаргаж ажиллаасай гэж хүсэж байна. Тэгээд танд амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Өнөөдөр Монгол Улсад Хүүхдийн байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ой тохиож байгаа. 100 жилийн ойг тохиолдуулаад хүүхдийн төлөө үйл ажиллагаа явуулдаг төрийн ба болон төрийн бус байгууллагуудад ажлын өндөр амжилтыг хүсье. Тэгээд хүний нийгэмд хүүхэдгүй орчин гэж хаана ч байдаггүй. Гэр бүлээс эхлээд үндэсний хэмжээнд хүүхдэд ээлтэй орчин нийгмийн дэд бүтцийг бүрдүүлж хүүхэд бүрд анхаарал хандуулж бүхнийг хүүхдийн төлөө гэсэн сайхан сэтгэлээр ажиллаж амьдрахыг нийт ард иргэддээ уриалж байна аа. Монголын үрс маш олон болтугай. Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс Хүүхдийн байгууллагын баярын мэндийг хүргэе ээ.

Мөн өнөөдөр манай чуулганы үйл ажиллагаатай танилцахаар Оюуны Ундраа сургуулийн 5 дугаар ангийн сурагчид хүрэлцэн ирсэн байна. Дүү нартаа сурлагын өндөр амжилтыг хүсье. Сурагчдын дунд манай Улсын Их Хурлын гишүүн Батын Батбаатарын охин Мишээл байгаа юм байна аа. Тэгээд баяр хүргэе. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууж үг хэлнэ.

С.Эрдэнэболд: Өнгөрсөн жил яг энэ 2025 оны төсөв ярьж байхад аудит төсөв дээр дүгнэлт хийсэн. Ингэхдээ үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд төсөв нийцэж байгаа талаар дүгнэлт хийсэн хэсэгтээ ерөнхийдөө агуулгын хувьд нийцэж байна гэдэг дүгнэлт хийгээд, яг нарийвчилсан дүгнэлт хийгээгүй. Яагаад нарийвчилсан дүгнэлт хийгээгүй юм бэ гэж асуухлаар үүнийг дүгнэлт хийх үнэлэх шалгуур үзүүлэлт нь тодорхойгүй гэдэг зүйлийг хэлж байгаа юм. Магнайсүрэн дарга аа. Тэгэхээр гол асуудал юу байна гэхлээр бид нар ингээд төсөв гэнгүүт 2 тийшээ туйлшраад байгаа юм. Нэг талдаа бол ингээд эдийн засгаа тэлэхийн хувьд төсөв ийм байх ёстой гэдэг загвар гаргаж ирэнгүүт нөгөө талд нь хэмнэх ёстой гэдэг ийм 2 туйлшралын дунд яваад ингээд Ерөнхийлөгч хориг тавиад, хоригийн ар дээр хөрөнгө оруулалтын төсвийг 20 хувь хасчихсан. Ингээд хасчхангуут чинь нөгөө эрүүл мэндийн салбар, боловсролын салбар гээд нийгэмд нөгөө хүртээмжит байдлыг бий болгодог салбарууд маань ингээд хасагдчихаж байгаа юм. Тэгэхээр энд хаана мэргэн ухаан гаргамаар байна гэхээрээ аудит төсөв дээр дүгнэлт гаргахдаа яг энэ үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын тэр 6 тулгуурт нийцэж байгаа талаар маш нарийн дүгнэлт гаргах юм бол бид ямар төсвөө өргөтгөх юм, ямар төсвөө танах юм гэдэг энэ улс орны хувьд маш чухал зүйлийг бид нар хийх боломжтой болж байгаа юм.

Тийм учраас та бол одоо олонхын дэмжлэг аваад өнөөдөр ингээд аудитаар сонгогдлоо гэхэд энийг ажил хэрэг болгомоор байгаа юм аа. Одоо энэ шалгуур үзүүлэлт тодорхойгүй байгаад байгаа зүйл дээр та санаачилга гаргаад араас нь хөөцөлдөөд, энэ төрийн ажил. Гэхдээ хувь хүний манлайлал итгэл үнэмшилтэй шууд холбоотой юм аа.

Тийм учраас Магнайсүрэн дарга та энэ дээр онцгой анхаараад энэ жилийн намрын төсөв хэлэлцэхээс өмнө энэ асуудлуудыг зохицуулалтын хувьд маш тодорхой болгох ёстой Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс жишээлбэл гаргана

гэсэн журам байгаа. Тэгвэл яг эндээс энэ рүүгээ чиглэсэн ажил хийгээд 2027 оны төсөв хэлэлцэхэд үүнийг аудитын байгууллага хяналт хийхдээ үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нарийн хянаж байгаа нийцүүлж байгаа талаар нь та дүгнэлт гаргах чадвартай байх ёстой. Нэг.

Хоёрдугаарт энэ дээр холбогдох Их Хурлын Байнгын хороонуудтайгаа хамтарч ажиллах нь зөв өө гэж үзэж байгаа. Эндээс үүдээд нэг л зүйлийг асууя. Улсын Их Хурал гэдэг бол онцгой бүрэн эрхтэй бөгөөд энэ бүрэн эрх нь ард түмэнд хадгалагдаж ард түмний төлөөлөл байдаг. Ямар ч аудитор хүн улс төрчдийн явцуу ашиг сонирхолд орж болохгүй, улс төрийн намуудын захиалгыг нь автаж болохгүй. Чин шударгаар өргөсөн тангарагтаа үнэнч энэ албыг залгуулах ёстой.

Тийм учраас энэ дээр өнөөдөр та өөрийнхөө итгэл үнэмшлийг тодорхойлооч гэж байгаа юм. Яагаад гэхээр энэ бол Улсын Их Хурлын протоколд үлдэх ёстой. Магнайсүрэн гэдэг хүн энэ албыг хийснээрээ ямар итгэл үнэмшилтэй, ямар зорилготой, төрийн үйлдэл, үйл ажиллагааг тасалдалгүйгээр залгамж холбоотойгоор урт хугацаанд яаж хийх вэ гэдэг итгэл үнэмшлээ та энэ микрофон дээр үлдээгээч гэж. Тэгээд түрүүний захиж хэлэх зүйл бол тэр үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд төсвийг нийцүүлэх дээр маш нарийн зохицуулалтууд хэрэгтэй байгаа. Энэ дээр та манлайлж хариуцлагатай ажиллаарай гэж хүсье ээ. Энэ асуултдаа хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон. Нэр дэвшигч Магнайсүрэн хариулт өгье.

С.Магнайсүрэн: Улсын Их Хурлын гишүүдийн өглөөний амгаланг айлтгая. Их Хурлын гишүүн Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя.

1 дүгээрт саяын хэлсэн үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлж төсвийн дүгнэлт гаргахтай холбоотой асуудлаар шалгуур үзүүлэлтийн асуудлыг та хөндөж ярилаа. Энэ асуудлыг хэрвээ би томилогдсон тохиолдолд мэргэжлийн холбогдох хүмүүстэйгээ судалж эргээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо Их Хурлын гишүүн танд танилцуулаад шаардлагатай бол холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар 2026 оны төсөв хэлэлцэхээс өмнө шийдвэрлэх ийм бүрэн бололцоо цаг хугацааны хувьд байна гэж би бол ингэж харж байна.

Тийм учраас энэ тал дээр би судлаад танд эргээд танилцуулъя.

Хоёрдугаарт нь Үндэсний аудитын газар гэдэг бол улс орны төсөв хөрөнгө, гаднын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүд болоод бүхий л санхүү төсвийн үр ашигтай захиран зарцуулалтыг арвич хямгач байдлаар зарцуулж байгаа эсэх байдал болон хууль тогтоомжийг хэрхэн хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавьдаг ийм үндэсний аюулгүй байдлын нүд чих болсон ийм гол байгууллага гэж ингэж ойлгодог. Тэгэхээр энэ байгууллагад бол хамгийн гол асуудал бол хараат бусаар ажиллах асуудал. Байгууллага нь хараат бусаар эрх зүйн орчинтой ажиллах ийм чухал шалгуур тавигддаг.

Тийм учраас энэ байгууллагад миний бие нэгэнт томилогдоод оччих юм бол тангараг өргөдөг. Мөн энэ ингэж хараат бусаар ажиллах ийм үүрэгтэй болдог. Энэ үүргээ бол нэр төртэй биелүүлэхийн төлөө бүх хүч чадлаа дайчилж ингэж ажиллана гэж ингэж амлаж байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууж, үг хэлье.

Да.Цогтбаатар: Гишүүдийнхээ өглөөний амар амгаланг айлтгая аа. Юуны өмнө Ерөнхий аудитораар ажиллаж байгаад энэ чөлөөлөгдөх гэж байгаа Загджав даргад баярлалаа гэж хэлэх ёстой байх. Оюу Толгой дээр ямар аймаар бузар үйл ажиллагаа явагдаж байгаа талаар үйлдэл хийж чадсан гэдэгт нь баярлаж байгаа юм. Бид нарт нууцын зэрэгтэй материал танилцуулсан. Гэхдээ Оюу Толгойг нээгдсэнээс нь хойш өнөөдрийг хүртэл аудитын байгууллагаас анхны нэг л дүгнэлт гарч ирсэн. Тэр дүгнэлтийг явуулж чадсан хүн нь Загджав дарга учраас Загджав даргад баярлалаа гэдгийг хэлье. Тэгээд шинээр нэр дэвшээд явж байгаа Магнайсүрэн даргаас асуух 2, 3 асуулт таны байр суурийг тодруулах гэсэн юм. 2018 онд аудитын байгууллагын төсөв 9.8 тэрбум байсан. Тэгээд энэ 2020 он гараад аудитын төсөв дабльдаж өссөн буюу 20 тэрбум болсон. Өнгөрсөн жил энэ жилээс бол бүүр 74 тэрбумаар орж ирээд одоо батлагдсан 54 тэрбумаар батлагдаад явж байгаа. Та бол төрийн мөнгөний нэг төгрөгийг ч гэсэн үнэ цэнтэй байлгахад анхаарч ажиллах ёстой хамгийн том хариуцлагатай албан тушаалтан. Аудитын байгууллага одоо миний сонссоноор бол 3 орлогчтой гээд байгаа юм. Орон тоо болон энэ хэрэгцээгүй шаардлагагүй зардлуудаа танах тал дээр таны байр суурь зөвхөн аудитын байгууллага дээрээ ямар үйл ажиллагааны шинэчлэлт хийх вэ гэдгээс таны байр суурийг нэг сонсох гэсэн юм.

Тэгээд 2 дугаарт нь болохоор энэ аудитын байгууллагын үйл ажиллагаа харьцангуй ил тод биш. Тэгээд энэ дээр та ил тод болгох тал дээр ямархуу ажлууд хийж хэрэгжүүлэх вэ? Дээрээс нь энэ төсвөөс гарч байгаа мөнгөн дээр жишээлэхэд Баянхонгор аймгийн энэ Баянговь сумд цэцэрлэг баригдаад 3 жил дөнгөж өнгөрөөд л суулт өгөөд хана нь нураад цэцэрлэг нурчих хэмжээнд оччихож байгаа юм. Энэ дээр хариуцлага ярья гэхээр барьсан компани нь 3 жилийнх нь хугацаа дуусчихсан гээд явчихдаг. Төрийн тэрбум 300 сая төгрөг үнэгүйдээд хоцордог. Сумын хүүхдүүд цэцэрлэггүй болоод хоцордог ийм хариуцлагагүйн зуд Монголд ер нь ингээд нэлэнхийдээ газар авчихсан байгаа. Энэ дээр таны цаашдын баримталж ажиллах байр суурийг тодруулмаар байна аа?

Тэгээд аудитаас тодорхой хэмжээний дүгнэлтүүд гардаг их бага хэмжээгээр. Гэтэл энэ гаргаж байгаа дүгнэлтүүд чинь нэг дүгнэлт гаргаад орхиод байдаг биш араас нь явж нэг хариуцлага нэхдэг, үр дүнд хүрдэг байх тал дээр нэг таны байр суурийг тодруулах хэрэгтэй байна. Яах вэ өнгөрсөн хугацаанд харахад бол нэг нам хэт олонхоороо засаг бариад ер нь 2 парламентын хугацаа буюу 8 жил явсан. Одоо нэг ийм стандарт бус Засгийн газартай явж байгаа. Тэгээд энэ дээр хазаарлах ёстой хамгийн үр дүнд хүргэх ёстой ажлын байран дээр нь та очиж байгаа. Энэ дээр таны цаашид баримталж ажиллах бас нэг зарчим тактик төлөвлөгөө гэдэг юм уу энэ дээр нэг таны байр суурийг сонирхож байна аа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон хариулт өгье.

С.Магнайсүрэн: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Аудитын зардал буюу төсөв жил ирэх тусам бас өсөж ирсэн байна лээ. 2025 онд таны хэлсэнчлэн 54 тэрбум төгрөг. Үүнээс хөрөнгө оруулалтынх нь зардал нь 1.1 тэрбум төгрөг. Бусад нь үндсэндээ урсгал зардал юм байна лээ. Тэгээд ер нь бол нийгэм эдийн засаг хөгжөөд эдийн засаг тэлэхийн хэрээр төсвийн хүрээ өргөжиж байгаа, төсөв тэлж

байгаа. Энэ утгаараа бас нөгөө шалгах ёстой объектууд буюу шалгагдагч этгээдүүд бол бас орж ирж байгаа гэсэн үг.

Тийм учраас энэ үүнийгээ дагаад энэ зардал төсөв өсөж байгаа, орон тоо нэмэгдэж байгаа ийм зүйл бол ингээд энэнтэйгээ уялдаад явж байгаа байх гэж ингэж ойлгож байгаа. Ер нь бол хамгийн чухал асуудал бол цаашдаа төсөв тэлэх гэхээсээ илүүтэй байгаа хөрөнгөө үр ашигтай, үр дүнтэй захиран зарцуулахад бол гол анхаарлаа төвлөрүүлэх ёстой гэдэг нь бол зөвхөн Үндэсний аудитын газар биш бусад төсөвт байгууллагуудын эрхлэх ёстой нэг ийм зарчим байх ёстой байх гэж ингэж ойлгож байгаа. Би хэрвээ томилогдсон тохиолдолд мэдээж төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулалтуудыг бол хязгаарлана. Өөрөө энэ дээр үлгэрлэн манлайлж ажиллах нь бол миний үндсэн үүрэг болно оо. Тийм учраас энэ чиглэлд би онцгойлон анхаарах ёстой. Анхаарч ажиллана. Орон тооны тухайд би одоогоор хэлж тийм ийм гэж хэлэхэд хэцүү байна. Судалж үзээд эргээд Төсвийн байнгын хороод байдаг юм уу Их Хурлын удирдлагатайгаа ярьж энэ чиглэлээр саналаа танилцуулж асуудлыг шийдэх ийм бололцоо гарах байх. Ер нь бол одоо үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдэх тусам хүний хүчээр хийнэ гээд хүнээ нэмээд байх нь зохистой байна уу? Шинжлэх ухаан технологийн ололт цахим энэ сүүлийн үеийн арга технологиудыг ашиглаад үр дүнтэй аудитыг хийх энэ арга замаа сонгоход хөрөнгө хүчээ бас төвлөрүүлж анхаарах уу гэдэг бас ийм судлах ажлууд байгаа. Энийгээ эргэж танилцуулж та бүхэнтэйгээ ярилцана.

Үйл ажиллагаагаа ил тод байлгах ёстой гэдэг дээр бол онцгойлон анхаарна. Яагаад вэ гэхээр зэрэг аудитын дээд байгууллагуудын ОУБ-аас гаргасан тунхаглалууд ялангуяа Лимагийн тунхаглал, Мехикогийн тунхаглалд бол энэ ил тод нээлттэй байх ёстой гэдэг энэ зарчим голчлон туссан юм билээ. 2020 онд баталсан Төрийн аудитын тухай хуулиар ч энэ асуудлыг бол хуульчлаад өгчихсөн байгаа. Тийм учраас ил тод байлгах тал дээр бол онцгойлж анхаарч ажиллана аа. Энэ тал дээр бол өнөөдрийн аудит дээр ч гэсэн тодорхой төлөвлөгөөнүүд гараад, стратегиуд гараад.

Д.Амарбаясгалан: Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууж үг хэлье.

Н.Наранбаатар: Ерөнхий аудиторт нэр дэвшигчийн намтартай танилцсан. Шаардлага хангаж байгаа юм байна гэж ойлгож байгаа. Хэдэн тоо баримт асууя гэж бодож байна. Бас саналаа хэлье гэж бодож байна. Бид бол төрийн албыг цомхон чадварлаг болгоно оо. Төсвийг хэмнэнэ. ТӨК-удыг хувьчилна. Нээлттэй болгоно оо, зардлыг багасгана гэж ярьдаг.

Дээрээс нь хэмнэлтийн хууль гаргана. Төсвийг хэмнэнэ гээд. Яг бодит байдал дээр энэ ярьж байгаагийнхаа яг эсрэг л юм хийгээд байгаа юм. Тухайлбал яамдын тоо нэмэгдэж байна, түүнийг дагаад төрийн албан хаагчдын тоо нэмэгдэж байна, төсөв зардал нэмэгдэж байна. Мөн хамтарсан Засгийн газар байгуулагдсанаас хойш олон зөвлөл хороод байгуулагдаж байна. Үүнийг дагаад мөн зардал төсөв нэмэгдэж байна. Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрууд, иргэдийн хурлын орон тоо улам л жилээс жилд нэмэгдэж байна. Агентлагуудын тоо, бүтэц, орон тоо нэмэгдэж байна. Төр бол үнэхээр нүдэн дээр данхайж байна. Тэгэхээр өнөөдөр Монгол Улсад хэчнээн төрийн албан хаагч байгаа юм, хэчнээн ТӨК байна, хэчнээн зөвлөл, хороод байна, тэнд хэчнээн төрийн албан хаагчид хэчнээн ТӨК-д төрөөс цалин авч ажилладаг хүмүүс байгаа юм? Энэ нэг тоо баримт тан дээр байна уу үгүй юу? Цаашид эдгээрийг цөөлөх багасгахад та хэрвээ томилогдвол ямар бодлого

барьж ажиллах юм? Энэ бол аль эсвэл зүй ёсны хэвийн үзэгдэл юм уу? Аль эсвэл байх хэмжээнээсээ давсан ийм үзэгдэл юм уу? 3 сая 500-хан мянган хүн амтай. Тэгээд ийм олон төрийн албан хаагчтай ТӨК-тай байж болох юм уу цаашдаа? Үүнийг цаашдаа яах юм гэдэг дээр та өөрийнхөө санаа үзэл бодлоо хэлнэ үү гэж.

Хоёрт нь энэ ЭМД-ын асуудал гэж хүнд төвөгтэй асуудал байх юм аа. Орон нутагт очоод ажиллахаар эмнэлэг дээр, эмнэлгийн ажилчидтай уулзалт хийхээр зэрэг энэ даатгалаас ирж байгаа санхүүжилт нь хүрэхгүй гэх юм. Энд ирээд яам, тамгын газарт нь хэлэхээр зэрэг болж байгаа гэх юм. Тэгээд энэ дээр ер нь цаашдаа аудит хийж яг юундаа байгаад байгаа юм гэдэг дээр нь онцгой анхаарч зөвлөмж дүгнэлт өгөхгүй болохгүй болсон ийм зүйл харагдаж байгаа.

Дараагийн дугаарт энэ төсөвт аудит хийж дүгнэлт зөвлөмж гаргаж байгаа. Тэгээд яг нэг Төсвийн хууль хэлэлцээд эхлэхтэй зэрэгцүүлээд энэ зөвлөмжөө өгдөг. Тийм учраас тодорхой хугацаа бидэнд өгч үзэх анализ хийх шинжилгээ хийх ийм боломжоороо хангаж байх хэрэгтэй гэж бодож байгаа.

Төсөв үргүй зарцуулсан маш олон зүйлүүд энэ төсвийн хөрөнгө оруулалт дээр сууж байгаа. Тухайлах юм бол 320 хүүхдийн сургууль, 960 хүүхдийн сургууль гэхэд л өөр өөр төсөвтэй, өөр өөр зурагтай гэх мэтчилэн төсвийг давхардуулан зарцуулсан маш олон асуудлууд энэ төсөв дээр байдаг. Тэгэхээр энэн дээр цаашдаа та нэлээн сайн анхаарч ажиллах хэрэгтэй.

Дараа нь энэ орон нутаг аймгуудад байгаа аудитын энэ байгууллагын орон тоо харилцан адилгүй байгаа. Хүн ам ихтэй, үйл ажиллагаа ихтэй хил боомттой ийм газрууд нь цөөхөн. Нөгөө үйл ажиллагаа багатай хүн ам цөөтэй аймгууд нь орон тоо ихтэй байдаг ч юм уу. Үүнийг цаашдаа уян хатан зохицуулж өгөхгүй бол зарим аймгууд чинь аудит хийх ямар ч боломжгүй, цаг хугацаагүй, төсөв хөрөнгө муутай ийм байдалтай байгаад байгаа шүү. Энэ дээрээ цаашдаа.

Д.Амарбаясгалан: Наранбаатар гишүүний асуултад хариулт өгье.

С.Магнайсүрэн: Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Төрийн байгууллагуудын тоо нэмэгдэж байгаа, орон тоо нэмэгдэж байгаа мөн хороо комисс гээд ингээд байгууллагууд байгуулагдаж байна гэсэн энэ асуудал сүүлийн үед нэлээн нийтлэг яригдаж байна. Өнөөдрийн байдлаар төрийн албан хаагчид чинь 230 орчим мянган төрийн албан хаагч гэсэн ийм би тоон мэдээтэй өөртөө ийм мэдээлэлтэй байна. Мөн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой төрийн болон орон нутгийн өмчтэй компаниудын бас нэг 60-аад мянган ажилтан ингээд 290-ээд мянган ажилтны ийм хүрээнд энэ асуудлууд яригдаж байна. Ер нь бол энэ төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт дээр бол төрийн албанд хууль дээдлэх зарчим тогтвортой байдлын асуудал мөн энэ чиглэлээрх хууль тогтоомжийн хэрэгжилтээр өнгөрсөн онд бол аудит хийсэн юм байна лээ. Энэ аудит бол одоо Улсын Их хурал дээр ирчихсэн. Тэгээд энэ аудит удахгүй Байнгын хороодоор хэлэлцэгдээд эхэлбэл нэлээн тодорхой ийм асуудлууд гаргаж тавьсан юм байна лээ. Зүгээр ерөнхий агуулга нь хэлэх юм бол хууль дээдлэх зарчим тодорхой түвшинд алдагдсан байна. Тогтвортой бүтцээр ажиллаагүй байна. Бодлого хуулийн хэрэгжилтэд тавих үр нөлөөтэй хяналтын тогтолцоо бүрдээгүй байна. Бүртгэл системийн доголдолтой байна гэсэн ийм ерөнхий ийм зүйлийг базаад хэлчихсэн ийм том аудитын дүгнэлт ороод ирчихсэн байгаа юм байна лээ

Их Хурал дээр. Энийг ойрын хугацаанд Их Хурал дээр танилцуулагдахад бол тодорхой асуудлууд яригдах байх гэж ингэж би хэлэх хэлэх байна. Ер нь бол данхайж юм уу ингэж нэмж явах нь цаашдаа боломж их та тааруу. Энэ бол төсвийн тэлэлтийг аль болохоор зардлыг хумихад чиглэсэн нөгөө төсвийн тогтвортой байдлын хуулийн үндсэн концепцод бол харшилна.

Тийм учраас аль болохоор нэмэх гэхээсээ илүүтэй цахим болон шинжлэх ухаан техникийн энэ инновац технологийн ололтыг ашиглаж илүү үр дүнтэй ажиллах энэ чиглэл рүүгээ бид анхаарах ёстой хүн хүчээ нэмэх гэхээсээ илүүтэй энэ чиглэлдээ илүү анхаарах ёстой болов уу гэсэн ийм зарчмыг хэлэх гэж байна.

Тэр ЭМД-ын болоод хүрэлцээ дутуу байгаа асуудал дээр бол аудит хийж болно. 2024 оны 12 сард бол аудитын сэдвээ 25 онд ямар сэдвээр хийх вэ гээд баталчихсан байна лээ. Энэ дотор бол яг энэ нэршлээр байхгүй байгаа. 2025 онд хийх аудитын сэдвийг бол тухайн онд хийх сэдвийг Төсвийн байнгын хороо баталдаг. Энэ хүрээнд бол бас Төсвийн байнгын хороон дээр санал гаргасан гишүүдийн саналыг би харгалзаж үзээд энэ дахиж энэ сэдвээ тодотгох боломжтой юм байна гэж үзсэн. Төсвийн төсөл дээр бол.

Д.Амарбаясгалан: Энэ төрийн албан хаагчдын тоотой холбоотой асуудал дээр нэг нарийвчилсан мэдээлэл бас энэ гишүүдэд өгөх нь зүйтэй юм шиг байгаа юм. Өөр өөр мэдээлэлтэй яваад байгаа юм. Нийтдээ 220 орчим мянган төрийн захиргааны, төрийн, тусгай, төрийн үйлчилгээний албан хаагчид байдаг. Төрийн өмчит үйлдвэрийн газарт нэг 60 орчим мянган хүн ажилладаг. Тэр 220 мянга дотор 70 хувь нь төрийн үйлчилгээний албан хаагчид байж байдаг. Сургууль, эмнэлэг, цэцэрлэгийн багш, ажилчид гэсэн үг. 21 хувь нь төрийн тусгай албан хаагчид, цэрэг, цагдаа, тусгай алба. 9 хувь нь төрийн захиргаа байгаад байгаа юм.

Тэгэхээр ер нь бол энэ төрийн албан хаагчдын тоо жил бүр яагаад өсөөд байдаг шалтгааны үндсэн нэг том хүчин зүйл нь бол энэ олон сургууль, цэцэрлэг нэмж баригдаж их хэмжээгээр ашиглалтад орж байгаа үндсэн шалтгаан энд байгаад байдаг байхгүй юу. Тэгэхээр энийг бид нар их тийм зөв ялгаж иргэд олон нийтэд мэдээллийг зөв өгч байхгүй бол төрийн захиргаа нь л тэр чигтээ данхайгаад л томроод байгаа юм шиг ойлгоод байвал бас өрөөсгөл байгаад байдаг юм байна лээ.

Наранбаатар гишүүн тодруулж асууя.

Н.Наранбаатар: Их Хурлын гишүүд Улсын төсөв дээр сууж аль болохоор хэмнэлттэй төсөв батлах гэж бол олон хоног ярьдаг. Бүүр нэг цэцэрлэгийг хүртэл оруулах уу, үгүй юу гэдэг дээр ярьдаг. Төсөв аль болохоор хэмнэх тухай ярьдаг. Гэтэл үүний хажуугаар зарим төрийн өмч дээр асар их хэмжээний төсвийг нэг ТУЗ-ийн 9 хүн сууж байгаад шийдээд байгаа шүү. Бид 120 зургуулаа улсынхаа төсвийг ярьж яаж хэмнэх тухай ярьж байхад тэнд нэг ТӨК-ийн ТУЗ, гүйцэтгэх захирал хэдэн их наяд 10, 20 их наядын төсөв яриад ингээд явж байгаа шүү. Тийм учраас цаашдаа энэ ТӨК-удын төсөв, түүний зарцуулалт, тэр бүтэц орон тоон дээр та нэлээн сайн анхаарч ажиллаарай л гэж хэлэх гэсэн юм. Баярлалаа. Амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя, үг хэлье.

Ц.Идэрбат: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол Улсын Ерөнхий аудитор чөлөөлөх, томилох асуудал хэлэлцэгдэж байна. Тэгээд аливаа хяналт

хяналтын байгууллагад төрийн албаны мерит зарчмаар явсан ялангуяа төрийн захиргааны албаар ингээд явсан хүн очих их зүгээр байдаг. Би тэр талаас нь их эергээр хүлээж авч байгаа. Төрийн албыг хийхэд бас янз янзын л олон асуудал дундуур явдаг, туулдаг, дүрэм журам нь зөрдөг барьдаг гээд зөндөө л юм байдаг.

Ялангуяа аудитын хууль өөрөө нэлээн сайн шинэчлэгдсэн. Аудитын байгууллагын гаргаж байгаа дүгнэлт бол нэлээн углуургатай ийм дүгнэлтүүд гардаг. Ийм болсон ийм үе. Тэгээд энэ дээр Монгол Улсын төрийн албаны мерит зарчмаар явж ирж байгаа хүн орж ирж байгаад талархалтай хандаж байна аа.

Аудитын хувьд бол ер нь улс орны хэмжээнд ч тэр орон нутгийн хэмжээнд ч тэр энэ төсвийн хөрөнгийн үр ашигтай зарцуулалт гүйцэтгэлийн аудитын дүгнэлтүүд нэлээдгүй гардаг. Улс орны хэмжээнд гишүүд нэлээдгүй олон зүйлийг хэллээ. Миний хувьд энэ аливаа төсвийг батлахад аудитын байгууллагын дүгнэлт зүгээр ингээд нэг танилцуулагдаад өнгөрдөг ийм зүйл биш байгаасай л гэж би 2 дахиаас хойш бараг хэлж байна.

Яагаад гэвэл мэргэжлийн аудитын байгууллагаас гаргасан энэ дүгнэлтийг Их Хурлын гишүүд бид ч гэсэн зүгээр ингээд нэг төсөв батлахад сонсоод өнгөрдөг ийм дүгнэлт бишээр хүлээж авч авах гээхийн ухаанаар нэлээн сайн хандах ёстой. Ийм зүйл юм билээ. Орон нутагт ялангуяа сүүлд орон нутгийн төсвийн хөрөнгүүд орон нутаг дахь төсвийн эрх мэдлүүд нэмэгдэж байгаа.

Дээрээс нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгүүд ч гэсэн жил болгон л нэмэгдээд явж байгаа энэ цаг үед тэрний гүйцэтгэлийн асуудал дээр би нэлээн анхаараасай гэж ингэж боддог юм. Энэ Улсын Их Хурлын Байнгын хороод дээр бас нэлээн танилцуулгууд хийгдэж яригдсан асуудал бол Монгол Улсад гадаад улсаас хэрэгжүүлж байгаа энэ төсөл хөтөлбөрүүдийн үр дүн, хэрэгжилт, гүйцэтгэл, төсвийнх нь ил тод байдал гээд энэ дээр бид ер нь маш нухацтай хандахгүй бол зүгээр л мөнгө орж ирж байгаа гэдэг агуулгаар ингээд яваад байдаг байж болохгүй юм билээ. Зарим яамдын танилцуулгыг сонсоход төрийн яаманд нь хүртэл төсвийнхөө төслийнхөө үр дүнг танилцуулдаггүй, төсвийнхөө задаргааг ч танилцуулдаггүй гээд нэг хэдэн мянган доллар ингээд явагдаад байдаг ийм зүйлүүд байдаг юм билээ шүү гэдэг дээр би анхаараарай гэж ингэж хэлэх гэж байгаа юм. Тэгээд гишүүдтэй аль болох давхардуулахгүйг хичээгээд байна. Дээрээс нь өнөөдөр Хүүхдийн байгууллагын 100 жилийн ой тохиож байна. Өнөөдөр Төрийн ордонд энэ баярын хурал болж байна.

Тэгээд энэ цаг үед бол бас өнгөрсөн парламент дээр Монгол Улсын хүүхэд хамгааллын хууль батлагдаж одоо энэ 9 сарын 1-ээс хэрэгжиж энэ 2025 оны 1 сарын 1-ээс Монгол Улсын нэгдсэн төсөв батлагдаад улс орон даяар хэрэгжиж байгаа энэ төсвийн жилүүд ингээд үргэлжилж байна. Эндээс авхуулаад л бид үнэхээр хүүхдийнхээ төлөө гэж хэлж байгаа юм уу үгүй юм уу. Энэ Монгол Улсад гарсан хууль хэрэгжих ёстой юу үгүй юу гэдэг дээр би аудит нэлээн сайн идэвх санаачилгатай ажиллаасай гэж хүсэж байгаа юм. Яагаад гэвэл орон нутаг дахь төслийн ерөнхийлөн захирагч нарт бол энэ хүүхэд хамгааллын хууль, түүнийг дагалдаж гарсан хуулиудаар нэлээдгүй үүргүүд оногдчихсон байгаа. Тэгээд энийг яг одоо эхний энэ жилийн хэрэгжилт дээр хэрэгжүүлж байна уу үгүй юу гэдэг дээр энэ шат шатын аудитын байгууллага нэлээн сайн хяналт шалгалтаа хийж хэрэгжүүлээгүй бол хэрэгжүүлэх дээр бас анхаарч ажиллаарай гэж ингэж би хэлэх гэж байгаа юм. Тэгээд танд амжилт хүсье ээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууж, үг хэлье.

П.Сайнзориг: Баярлалаа. Нэр дэвшиж байгаа Магнайсүрэн нэр дэвшигчийг дэмжиж байна аа. Төрийн ажлын туршлагатай. Эрх зүйн чиглэлээр мэргэшсэн төрийн захиргаагаар мэргэшсэн ийм хүн орж ирж байгаад талархаж байна. Төрийн аудитын тухай хууль бас шинэчлэгдээд нэг их удаагүй байгаа. Тэгэхдээ би бас ерөнхий суурь концепц зарчмын хувьд зөв тавигдсан гэж боддог энэ хуулийг. Тэгэхдээ нэг жоохон тодруулаад аваад үзэх юмнууд байна. Таныг бас одоо төрийн аудитын энэ үйл ажиллагаа чиг үүргийг илүү их оновчтой зохистой, эргээд энд үр дүнтэй байлгахад анхаарч зарим зүйлийг судалж авч үзээсэй гээд хэдэн санааг хэлэх гэсэн юм.

Нэгдүгээрт энэ төрийн аудит бүх энэ төрийн байгууллагуудад угаасаа хүрч ажиллаж аудит хийх бололцоогүй байдаг. Гэрээт аудит буюу гэрээгээр энэ хувийн компаниудыг тодорхой хуулийн этгээдүүдээр аудит хийлгэх энэ жагсаалтыг баталдаг юм аа. Тэгээд энэ жагсаалт ерөөсөө энэ банк санхүүгийн сектор шиг л болчихсон гээд байх юм байна лээ. Ерөөсөө энэ төрийн аудитын байгууллагад ажилладаг хүмүүсийн компани энэ жагсаалтад ордог. Өөрөөр хэлэх юм бол энэ төрийн аудитын байгууллагын шат шатад ажиллаж байгаа хүмүүсийн хувийн компани, хамаарал бүхий компаниуд энэ аудитын хувийн компаниудын ард байж гэрээгээр аудит хийдэг энэ нөхцөл байдалтай уялдаатай байдгаа. Энийг ер нь эрх ашгийн гэдэг юм уу ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах талаас та бас нэг бодлогын түвшинд нэг судалж энэ дээр нэг шийдэл гаргаач гэж 1 дүгээрт хүсэж байгаа юм.

Хоёрдугаарт энэ төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой орон нутгийн өмчийн оролцоотой компаниуд дээр хувьцаат компани болчихсон нь бирж дээр л гарчихсан компаниудын бас энэ аудит хийлгэх энэ шаардлага нь өөр байдаг. Гэтэл төрийн аудит хийлгэх хугацаа нь бас өөр байдаг. Энэнээсээ зөрчилдөөд нөгөө ноогдол ашгийг хуваарилах энэ үнэт цаасны зах зээлийг зөв зохистой эдийн засгийн эргэлтэд оруулж дэмжиж өгөх энэ асуудал зөрчилдөөд байгаа. Энэ зөрчлийг та бас нэг арилгах талаас нь нэг анхаараад яг энэ олон нийтэд нээлттэй болж байгаа энэ ХК-ийн энэ үнэт цаасны зах зээлийн бодлого шийдвэрт нь нийцүүлээд энэ жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлд нь нэг анхаарч энэ хууль тогтоомжийн уялдааг хангахад нэг анхаараач гэдэг зүйлийг хэлмээр байгаа юм.

Хоёрдугаарт энэ аймаг аймаг дээр ч юм уу ийм аудитын газрууд байдаг юм байна лээ. Тэгэхээр энийг ерөнхийдөө нэгтгэж томсгох бодлого баримтлах талаас та судалж үзээч гэж байгаа юм. Баруун бүсийн аудитын газар, Төвийн бүсийн аудитын газар, Зүүн бүсийн аудитын газар гэх байдлаараа аймагт биш бүсчилсэн хөгжлөөрөө ингээд явах юм эрх ашиг гэдэг юм уу явцуу эрх ашигт нөлөөнд орохгүй байх, нөлөөнд автахгүй байх энэ чиглэлдээ илүү их үр дүнтэй байж болох болов уу гэж зүгээр би хувьдаа боддог. Тэгээд энэ бүх зүйлүүдийг нэг авч үзээч.

Хоёрдугаарт яах вэ улс төрчдийн нэг аваад нэг мушгиж тайлбарладаг ийм нөгөө хязгаарлалттай дүгнэлт буюу нөгөө хугацаандаа шилэн данс дээр тавиагүй ч гэдэг юм уу ингээд нэг том тоо харагдаад төсвийн мөнгө эсвэл нийтийн энэ өмч ингээд буруу зарцуулагдаж байгаа юм шиг ийм зүйлүүд ингээд явчихдаг аа.

Тэгэхээр энэ бүх зүйлүүдийг мэдээллийг олон нийтдээ өгөх, энэ асуудал дээр анхаараач.

Хоёрдугаарт аудитын байгууллагаар ингээд гэмт хэргийн шинжтэй зүйлүүд гарч ирсэн тохиолдолд энийг хууль хяналтын байгууллагад өгдөг. Тэгэхдээ зарим зүйлүүд нь бас ингээд дарагдаад хоцордог юм шиг байгаа юм. Тэгэхээр энэ зүйлүүдийг бас илүү их анхаарч бас яваач гэдэг зүйлийг л би хэлмээр байна. Тэгээд бас танд ажлын амжилт хүсье. Би зүгээр санал хэлж байгаа. Энэ зүйлүүдийг цаашдаа бас ажил хэрэг болгох талаас нь анхаарч үзээч. Би зүгээр яах вэ энэ хууль эрх зүйтэй холбоотойгоор энийг сайжруулах зайлшгүй шаардлагууд байна аа. Таныг томилогдсон тохиолдолд энэ зүйлүүдийг нэг бодолцож судалж үзээрэй л гэдэг зүйлийг санал болгож хэлж байгаа юм аа.

Тэгээд Магнайсүрэн нэр дэвшигчийг дэмжиж байна аа.

Д.Амарбаясгалан: Сайнзориг гишүүн үг хэллээ. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууж, үг хэлье.

О.Цогтгэрэл: Гишүүдэд өглөөний мэнд хүргэе. Аудитын байгууллага гэдэг төрийн төсөв санхүүтэй холбоотой хяналт шалгалт үр өгөөжийг ингээд ярьдаг байгууллага гэж бид нар ойлгодог. Яг нарийндаа төрийн мөнгө гэж бас байхгүй, татвар төлөгчдийн мөнгө. Тэгэхээр энэний цаана гарч ирэх үндсэн асуудал нь бид нар төрд цугласан татвар төлөгчдийн мөнгийг үр ашгийг хянах. Тэгэхээр ер нь энэ төрийн үндсэн асуудал чинь өөрөө бид нар, яг өнөөгийн бид нарын явж байгаа шийдлийн үндсэн асуудал чинь, проблемын тулгамдсан үндсэн асуудал чинь бусдын улс төрчид гээд хэдэн нөхдүүд тэр тусмаа парламент дээр ард түмний татвар төлөгчдийн мөнгийг цуглуулж авчирчхаад бусдын мөнгийг цуглуулчхаад бусдын төлөө шийдвэр гаргах гэж байгаа ийм хүмүүс. Энэний цаана чинь өөр өөр хувилбарууд байдаг. Өөрийнхөө мөнгийг өөрийнхөө төлөө зарцуулах гэж байгаа ард иргэд, бизнес эрхлэгчид, өөрийнхөө мөнгийг бусдын төлөө, бусдын мөнгийг өөрийнхөө төлөө гээд. Тэгэхээр энэ дундаас хамгийн хариуцлагагүй шийдвэр гаргадаг нь бусдын мөнгийг бусдын төлөө зарцуулах гэж байгаа энэ төрийн шийдвэр гаргагчид л гэж үздэг.

Тэгэхээр энийг хянана гэдэг бол өөрөө тийм хамгийн төвөгтэй эрх мэдэл бүхий хэсгийн гаргачихсан энэ шийдвэрийг. Тэгэхээр энэний цаана уг нь бол уг нь бол баахан татвар төлөгчдийн мөнгийг бусдын мөнгийг цуглуулчхаад бусдын мөнгийг бид нар тараачхаад дахиад энүүндээ аудитын байгууллагаар хяналт хийлгэнэ гээд энэ нэг том бодлогын бодлогыг уг нь бол бид нар өөрсдөөр нь өөрсдийнх нь мөнгийг өөрсдийнх нь төлөө буюу бага татвараар бага төрөөр цомхон төрөөр хийлгэх үндсэн нэг ийм бодлогын шилжилт л буруу тал руугаа л Монголын төр дээр үеийн үед л ингээд явсаар ирсэн ийм л нөхцөл байдал бий. Тэгээд бид нар бол нэг гараараа төрийг томруулдаг, нөгөө гараараа их мундаг хянадаг баатрууд болоод. Яг өнөөдөр ингээд аудитын байгууллага бол үнэхээр нэг ийм ацан шалаатай хэцүү үед л байна гэж миний хувьд боддог. Яагаад гэвэл яг саяынхаар төсөв хамгийн их томорчихсон, төр хамгийн их томорчихсон, ТӨК-уд нь хамгийн их томорчихсон энэн дээр ч хяналт хийх гэж байгаа. Дахиад дээрээс нь яг өнөөгийн улс төрийн нөхцөл байдал нь ийм үед, ийм их мөнгийг хянах гэж байгаа үед улс төрийн намуудын хамтрал Засгийн газрын хамтрал бий болчихсон.

Улс төрийн томоохон шийдвэр, дүгнэлт, байр сууриа илэрхийлэхэд хэцүү ийм нөхцөл байдалд л аудитын газар гэдэг энэ байгууллага өөрөө нэг ийм ацан шалаатай ийм л нөхцөл байдалд очиж байна. Тэгэхээр энэ энийг ацан шалаа гэлгүй энийг ийм улс төрийн дарамт шахалт гэлгүйгээр уг нь энэ төрөөс хүлээсэн Улсын Их Хурлаас шууд томилогддог ийм бусдаас хараат бус ажиллах ийм хуулийн боломж бололцоотой байгууллагын хувьд олон олон зүйлүүдийг хийх ийм л шаардлагатай. Энэ дотор дахиад л нэмээд хэлэхэд зөвхөн ТӨК-уд гэхэд эдийн засагт ямар их хувь хэмжээ эзэлж байгаа билээ. Тэгтэл ТӨК-удыг нь өнөөдөр ТӨК компаниуд дээр зөвхөн төрийн аудит л аудит хийнэ гэсэн хууль явж байдаг. Энэний цаана ТӨК-уд энэний цаана зөвхөн төрийн аудит, аудит хийнэ. Энэ аудитад итгэх итгэл тэр тусмаа бид нар компаниудыг олон улсынх болгоё, нээлттэй болгоё, бирж, зах зээл дээр гаргая гэж байгаа энэ үед жишээ нь энэ шинээр хэрвээ томилогдоод явбал аудитын байгууллагын дарга энэн дээр бас өөрийн байр суурьтай аль болох энэ төвлөрсөн тогтолцоог задлах мэргэжлийн байгууллагууд, хараат бус байгууллагууд, хөндлөнгийн байгууллагууд, олон улсын аудитын дэлхийн дэг жаяг руу орж ажиллах олон олон зүйл бид нарын энэ ирээдүй цаг дээр хүлээгдэж байна л гэж боддог. Тэгээд анхаарч ажиллах олон зүйл байна гэдгийг л хэлье дээ.

Д.Амарбаясгалан: Цогтгэрэл гишүүн үг хэллээ. Болдын Уянга гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Уянга: Төрийн албаны тухай хууль болон Төрийн аудитын тухай хуулийг хуульд заасан шаардлагыг бүрэн хангасан нэр дэвшигч өнөөдөр нэр дэвшиж орж ирж байгаад баяртай байна аа. Таныг бас бүрэн дэмжиж байгаа. Тэгээд Магнайсүрэн даргатай хуучнаар Уул уурхай хүнд үйлдвэрийн яаманд таны ТНБД-аар ирэх үед хамтарч ажиллаж байлаа. Тэгээд тухайн үед яамнаас гарч байсан бичиг, бүхий л тэр эрх зүйн актууд, ямар нэгэн хуулийн заалт зүйлийн зөрчилгүйгээр найруулгын хувьд өндөр түвшинд бэлтгэгдэж ер нь нэг төрийн албаны нэг үйл ажиллагаа цэгцэрч байсан юм шиг тийм мэдрэмжийг авч байлаа. Мөн Ашигт малтмалын тухай хууль дээр ажиллаж байхад ч гэсэндээ нэлээн нарийн мэргэжлийн салбарыг ойлгож түргэн шуурхай хамтарч ажиллаж байсанд нь энэ завшааныг ашиглаад талархахыг хүслээ.

Тэгээд аудитын байгууллага ч гэсэн энэ хэрээрээ таныг томилогдоод очих үед нэлээн тийм жигдрэх сайжрах ийм нөхцөл бүрдэх байх гэж найдаж байна. Танд амжилт хүсье ээ.

Тэгээд ийм 2 санал байгаа юм. Сүүлийн жилүүдэд бол аудитын байгууллагаас гаргасан аливаа дүгнэлтүүдийг нэлээн нягт тэгж уншиж судалдаг боллоо. Тэгээд үзэх бүрд бол одоо бид нарын ярьж байгаа бүхий л жижиг жижиг, том том тоо, бүхий л төрлийн асуудлууд ямар нэгэн байдлаар аудитын тайланд туссан байдаг аа. Хэрвээ тухайн тайланг уншаад хэрэгжүүлсэн бол төлөвлөлтдөө оруулсан бол өнөөдөр зарим асуудлууд жигдрэх байхгүй болох түвшиндээ хүрэх байсан байх гэж бодож байгаа. Тэгэхээр яг энэ аудитын зөвлөмж гаргаад анхаарах асуудлууд нь бичигдсэн тохиолдолд тэр нь ямар нэгэн байдлаар хэлэлцэгддэг байх, төлөвлөлтөд нь суудаг байх дээр та анхаараад өгөөрэй гэж хүсье.

Хоёрдугаар зүйл нь болохоороо яах вэ зүгээр санхүү гүйцэтгэл, үйл ажиллагааны тайлангуудад аудитын дүгнэлтийг танай байгууллагаас гаргадаг. Тэгэхдээ энэ гүйцэтгэлийн аудит хийхээсээ өмнө магадгүй төлөвлөж байх үед нь аудитын байгууллагаас анхаардаг бол ер нь яадаг юм? Тэгвэл яг ингээд гүйцэтгэл

дээр нь ч гэсэн та хэдийн үгийг авахад хүртэл амар болох юм болов уу? Энэ дээр ямар шийдлүүд байх боломжтой бол? Энэ дээр хамтарч ажиллахад бэлэн байгаа. Тэгээд Магнайсүрэн даргыг дэмжиж байна. Танд ажлын амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Чинбатын Ундрэм гишүүн үг хэлье.

Ч.Ундрэм: Нэр дэвшиж байгаа Магнайсүрэн даргыг дэмжиж байгаа. Яг одоо энэ төрийн албанд мэргэшсэн, мерит зарчмаараа ингээд явж байгаа хүн учраас тэгээд танд захих хэдэн зүйл байгаад байна аа. Өнөөдөр энэ асуулт асууж, үг хэлж байгаа гишүүд бүгдээрээ л энэ ТӨК-удын талаар бүгд санаа зовоод ярьж байна. Тэгээд энэ бол зүгээр бас нэг юм яримаар байгаа учраас яриад байгаа биш үнэхээр тэнд анхаарах шаардлагатай юмнууд байна. Өнгөрсөн хугацаанд манай аудит бол гайгүй сайн ажиллалчирдаг. Тэр дүгнэлтүүдийг нь яг нарийн уншаад танилцаад тэрийгээ ажил албандаа хэрэглэвэл маш чухал дүгнэлтүүд гардаг. Гагцхүү одоо жишээлбэл төрийн өмчит үйлдвэрийн газар сөрөг дүгнэлт 2 жил дараалж аваад байхад нөгөө гүйцэтгэх захирал нь жинхэлчихдэг, сайн ажиллалаа гэж шагнаж байгаа юм уу, сөрөг дүгнэлт авч байж жинхлүүлэх ёстой байсан юм уу гээд. Энэ аудитын газрын дүгнэлт ерөөсөө дараа дараагийн ажил хэрэгт тусгагдахгүй. Энэ дээр үндэслэж дараа дараагийн шийдвэрүүд гарахгүй. Ийм нөхцөл байдлууд үүсээд байгаа юм аа.

Тэгэхээр энэ дээр та өнөөдөр манай аудитын газар нэг тийм шүдгүй арслан шиг нэг дүгнэлт гаргачирдаг, тэр нь зүгээр цаас болоод тэр их ажил тиймээ цаас болоод үлддэг биш, араас нь арга хэмжээ авагддаг тийм хууль, эрх зүйн шинж бичлэгийг аудит дотроосоо санаачлаад хийх юм бол энд Их Хурлын гишүүд бүгд санаа зовдог учраас дэмжээд явна гэж би бодож байгаа. Тэгээд одоо жишээлэх юм бол зарим орон нутгийн иргэдийн хурал, хувийн компаниудтай хамтраад алтны компани байгуулчихсан байгаа байхгүй юу. Тэгээд ингээд алт ухаад, байгаль орчин сүйтгээд ингээд явж байгаа газрууд байна. Өнөөдөр бас Идэрбат гишүүн хэлж байна. Хүүхдийн байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ой гээд тэгж байна. Энэ хүүхдийн амралтын газрууд гээд биднийг жоохон байхад зөндөө газрууд байдаг байсан. Эд нар бас бараг бүгд хувьчлагдчихсан. Ихэнх нь хууль бус хувьчлагдсан шүү. Ялангуяа энэ орон нутгаар байгаа хүүхдийн амралтын газрууд бол бүгдээрээ хууль бус хувьчлагдсан байгаа.

Тэгээд энэтэй холбоотой мэдээллүүд орон нутгийн аудитын газрууд чинь бол тодорхой хэмжээгээр байгаа л гэж бодож байна. Дүгнэлт нь гараад байдаг. Араас нь ерөөсөө арга хэмжээ орон нутгийн түвшинд ч тэр, Их Хурлын түвшинд, засгийн түвшинд ч тэр ерөөсөө авагддаггүй. Тэгэхээр араас нь хариуцлага тооцдог ийм л Аудитын хуультай болмоор байгаа юм. Аудит бол Улсын Их Хурлын баталсан хууль, тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт ямар түвшинд байна гэдгийг хянаж үздэг ийм Улсын Их Хуралдаа үйлчилдэг байгууллага. Тэгэхээр доошоогоо энэ засагт байгаа болж бүтэхгүй бүх зүйлийг эндээ мэдээлээд эргээд бид нар араас нь хөөцөлдөж арга хэмжээ авдаг, засаж залруулдаг, ийм л байхгүй бол одоо ингээд аудит сөрөг дүгнэлт гаргадаг, хязгаарлалттай дүгнэлт гаргадаг, тэгээд л өнгөрдөг юм гээд хүмүүс бараг тоохоо байж байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр Их Хурал ч тэр, Аудитын газар, Магнайсүрэн дарга ч тэр цаашид анхаарах ёстой шүү гэж хэлмээр байна аа.

Тэгээд танд амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Чулуунбилигийн Лодойсамбуу гишүүн асуулт асууж, үг хэлье. Алга байна. Дашдондогийн Ганбат гишүүн алга байна. Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууж, үг хэлье ээ.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе. Манай улс иргэд, аж ахуйн нэгжийн төлсөн татварын төгрөг бүрийг үр ашигтай, үр нөлөөтэйгөөр төлөвлөж, төсөвлөж зарцуулалтын хяналт үнэлгээг хийх ёстой. Харамсалтай нь манай төрийн байгууллагууд бодлогын хэрэгжилт, төсөл арга хэмжээнийхээ хэрэгжилт 2-ыг хооронд нь холиод ялгаж салгаж чадахгүй буруу төлөвлөөд буруу төсөвлөөд татварын орлогыг өндөр үр ашигтайгаар зарцуулж чадахгүй байгаад байгаа юм. Та энэ алдааг яаж засахаар төлөвлөж байна аа? Сүүлийн 10 жилд та ТНБД-ыг 3 яаман дээр хийсэн байна. Олон төлөвлөгөө төсвийг боловсруулж баталж зарцуулах шийдвэрүүдийг гаргаж байсан гэж бодож байна. Ямар зарчим баримтлах вэ та гэсэн эхний асуулт байна.

Хоёрдугаар асуулт нь болохлоор төрөөс гадна нөгөө талдаа орон нутгийн удирдлагууд бас яг адилхан зөв төлөвлөж, төсөвлөж, татвар төлөгчдийн мөнгийг зөв зарцуулаад тэрийгээ хянаж, тайлагнаж чадахгүй байгаад байгаа юм. Жишээ нь 2023 онд орон нутгийн хөгжлийн санд 544 тэрбум төгрөг төсөвлөсөн боловч зарцуулалтаас нь 163 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн ийм том асуудал байгаад байгаа юм. Энэ дээр 2, 3 шалтгаан байгаа гэж бодож байна л даа. Эхнийх нь болохоор иргэд оршин суугчдаас санал авахгүйгээр ИНХ-ын дарга нар төсөв тавиад төсөл хэрэгжүүлээд явчихдаг. Энэ сангийн зарцуулалтыг оршин суугчид өөрсдөө шийдэх, ёстой. Баг, хорооны түвшинд гудамжаа тохижуулах хүүхдийн тоглоомын талбай барих, моджуулах, зүлэгжүүлэх, нийтээрээ нийлээд био жорлонтой болох, халаалт цахилгаанаар халаах юм уу сэргээгдэх эрчим хүчээр халаах юм уу гэсэн тийм утаа, хөрсний бохирдлыг бууруулж болохоор ажлуудыг иргэд өөрсдөө санаачлаад тухайн төслийг өөрсдөө хэрэгжүүлэх юм бол үр дүнтэй зарцуулах боломж бий болох боловч сүүлийн 10-ад жил энийг хийж чадаагүй байгаад байгаа. Энийг засах санал төлөвлөгөө танд байгаа юу гэсэн ийм 2 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Жуковын Алдаржавхлан гишүүн. Аан асуултад хариулъя 9 дүгээр микрофон.

Г.Магнайсүрэн: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Төрийн аудитын байгууллагын хуулиар хүлээсэн нэг үндсэн чиг үүрэг бол энэ төсвийн төлөвлөлтийг зөв болгох, орлогыг одоо орлогодоо уялдсан зарлагыг тооцож дүгнэлт гаргах, зарлагыг аль болохоор нэмэгдүүлэхгүй байх ялангуяа төсвийн алдагдлыг алдагдалтай төсөв батлуулахгүй байх ийм чиглэл онцгойлон барих ийм зарчимтай. Төсвийн төсөөллийн тухай болон энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу бол 2025 оноос төсөв алдагдалгүй батлахаар цаашдаа ашигтай байхаар ийм шалгуур үзүүлэлт зарчим батлагдсан. Энэ хүрээнд 1 дүгээрт ажиллах ёстой.

Хоёрдугаарт, улсын төсвийн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөв болон өргөн мэдүүлэх төсөв, мөн аймгийн НИТХ-д өргөн мэдүүлсэн болон өргөн мэдүүлэх төсөл дээр төрийн аудитын байгууллага бол төсвийн орлогыг сайжруулах, зарлагыг үр ашигтай үр дүнд чиглэсэн байдлаар тэгээд холбогдох бодлогын баримт бичгүүдэд нийцсэн байдлаар батлуулах тэр саналыг бол гаргаж ингэж хуулийн хугацаанд хүргүүлдэг. Энэ бол хуулиар хийх Үндэсний аудитын газрын нэг чиг үүрэг

буюу аудит хуулиар хийх аудитын нэг нь нэг үндсэн асуудал нь байж байгаа юм. Тэгэхээр аудитын байгууллага бол аль болохоор одоо бодлогын баримт бичгүүд, урт хугацааны болоод дунд хугацааны мөн богино хугацааны буюу тухайн жилийн бодлогын баримт бичгүүдийг нийцүүлж уялдаа холбоог нь хангаад хүрэх бүрд нь цаг хугацаа хүч хөрөнгийг нь төлөвлөөд ингээд дүгнэлтээ өгдөг. Гол нь бол одоо асуудлыг шийдэх шийдэл нь бол хурлууд дээр гарч байгаа. Орон нутгийн хурал, Улсын Их хурал.

Тийм учраас энэ чиглэлд бол хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхийн мэргэжлийн чиг үүргээ та бүхэнд хангалттай өгч ажиллах энэ чиглэлээр л хичээж ажиллана л гэж ингэж хариулах байна.

Хоёрдугаарт тэр орон нутгийн чиглэлтэй тэр тусгай сангууд бол аудитын байгууллагын нэг шалгагдах объект байдаг. Энэ сангуудыг бол мөн аудит хугацаандаа хуульд заасны дагуу хийдэг.

Хуульд заасны дагуу хийгдэх аудит дээр нь төлөвлөгөөт аудит гэж байгаа. Тэгэхээр төлөвлөгөөт аудитын сэдвийг бол Төсвийн байнгын хороогоор баталдаг. Энэ хүрээнд бол бид нар Төсвийн байнгын хороон дээр энэ орон нутгийн санг ч юм уу тодорхой асуудлуудыг бид нар сэдэв болгож аваад тухайн ондоо хэрэгжүүлэх ийм бүрэн бололцоотой байгаа. Энэ хүрээнд бол бид нар таны хэлсэн асуудлуудыг анхаарч аудитын сэдэв болгоод цаашдаа явах ийм бололцоо байгаа. 2025 оны аудитын сэдэв бол 2024 оны 12 сард батлагдсан, 41 сэдэв ингээд батлагдчихсан байж байгаа. Тэгээд энэ хүрээнд бол түрүүчийн ярьсан гишүүдийн зарим асуудлууд сэдэвт ороод.

Д.Амарбаясгалан: Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууж, үг хэлье.

Д.Ганбат: Нэр дэвшигч маань Хуулийн шаардлагыг бол хангаж байгаа юм байна аа. Хуулийн шаардлагыг хангаж байгаа гэж ойлгож байна. Ер нь бол өнөөдөр бол улс орны нөхцөл байдал хүн хүнд байгаа. Улсын Их Хурлаас томилогддог байгууллагууд, тухайлбал Аудитын ерөнхий газрын даргыг маань сонсгол хийгээд ингээд шат дараатай оруулж ирж байгаа нь их зөв юм аа. Ер нь томилгоо нэг иймэрхүү маягтай л явах ёстой л доо. Бид нарын байгаа байдал бол улс орны байгаа байдал, өнөөдрийн төр засгийн энэ орон тоо, төсөв энэ бүх юм данхайсан байдлыг харахад бол аудитын хийх ажил маш их байна аа. Тэгээд танаас асуухад аудит мэдээж хэрэг очих гэж байгаа орон тоо юм хумаа та бүхэн харсан байгаа байх аа. Аудитын бүтэц, ажиллах байдал ямар байгаа вэ? Хамгийн эхний ээлжид та юун дээр анхаарч ажиллах гэж байна вэ гэсэн ийм асуулт байна аа.

Би Баянхонгор, Өвөрхангай, Архангай аймгаас сонгогдсон гишүүний хувьд ХАА-н кластер төсөл гэж манай Баянхонгор аймагт хэрэгжиж байгаа. Улсын төсвөөс бүх мөнгө нь санхүүжигдээд дуусаж байна. Энэ дээр би таныг аудит оруулахыг хүсэж байна аа. Тэнд мах ногооны зоорь бий болчихсон байх ёстой ажиллаж байх ёстой. Ингэний сүүний үйлдвэр ашиглалтад ороод ажиллаж байх ёстой. Мөн тэжээлийн үйлдвэр ажиллах ёстой гэх мэтчилний улсын бараг 20, 30 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт сүүлийн 5, 6 жилд ороод ингээд ажилласан байгаа. Энэ дээр аудитын байгууллага орж энэ бүх юман дээр үр дүн хэрэгжиж байгаа ажил ямар байгаа талаар оруулах нь зөв байх гэж бодож байна. Энэ дээр таны боломж бололцоо аудитын байгууллага нь яаж ажиллах вэ гэсэн зүгээр нэг жишиг жишээ аваад нэг та нэг тайлбарлаад хэлээдхээч гэсэн ийм зүйл байна аа.

Нийт манай хяналтын асуудал маш их хоцрогдож байгаа. Ер нь бараг хүнд хэцүү байдал байгаа гэж хэлэхэд болно. Энэ улсын төсвийн хөрөнгө оруулалт гэсэн ийм юман дээр ер нь манай харж байхад бол байж байгаа байдал бол сүүлийн үед улсын төсөв бол их том томорсон байгаа. 4, 5 жилийн өмнөхөө бодоход бараг 5, 6 дахин томорсон ийм байдалтай байна аа. Тэгэхээр та нарын ажил бол 5, 6 дахин нэмэгдэнэ л гэсэн үг. Энэний үр дүн бол маш муу байгаа л даа. Хангалтгүй гэсэн ийм байгаа байдалтай. Энэ Монгол Улсын ард түмний амьдрал доройтож байгаа. Энэ бүх байдлаас харж болохоор байна. Тэгээд нэгэнт Улсын Их Хурлаас томилогддог ийм байгууллагын хувьд бас энэ ажлыг үнэхээр тэр аудитын хэмжээнд хийдэг түвшинд нь гартал хийх шаардлага байна гэж үзэж байна. Энэ дээр хэр ажиллах вэ гэсэн ийм асуултууд байна.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Асуултад хариулъя. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

С.Магнайсүрэн: Ганбат гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт Үндэсний Аудитын газар бол орон нутагтаа 21 аймаг, нийслэл ингээд 22 байгууллагатай. Тэгээд Үндэсний Аудитын Газар гэсэн ийм 23 байгууллагын бүрэлдэхүүн бүхий ийм тогтолцоотой үндэсний хэмжээний байгууллага юм байна. Орон нутагт нэг 400 орчим хүний орон тоогоор үйл ажиллагаагаа явуулдаг. Төвдөө бол нэг 2 зуугаад хүний орон тоотой үйл ажиллагаа явуулдаг юм байна лээ. Бүтэц зохион байгуулалтын хувьд бол тийм ийм гэж би одоогоор хэлж чадахгүй байна. Судлах шаардлага гарна. Эргээд Их Хурал Төсвийн байнгын хороотойгоо ярих шаардлага гарах байх. Ер нь бол гишүүдийн сая сонсгол, Төсвийн байнгын хороо өнөөдрийн хуралдаан дээр хэлж байгаа асуудлаас бол энэ аудитын дүгнэлт шийдвэрүүдийн хэрэгжилтэд онцгой анхаарах ёстой гэдэг нэг ийм зүйл бол нэлээн олонтоо давтагдаж тод яригдаж байгаа.

Тэгэхээр магадгүй энэ чиглэл рүү анхаарсан хандсан бүтэц, орон тоо чиглэх ийм зүйл байж магадгүй. Дээр нь бол зарим талаар энэ нөгөө нэмэгдсэн орон тоонууд захиргаа руугаа голлоод чиглэсэн ийм зохион байгуулалтууд хийгдсэн байна. Мэргэжлийн буюу аудит хийдэг тэр үндсэн чиглэл рүү нь анхаарахад чиглүүлэх ёстой биш үү гэсэн ийм асуудлууд гарсан учраас энэ асуудлуудыг анхаарна гэж бодож байгаа.

Хоёрдугаарт нь бол өнөөдрийн энэ гишүүдийн ярьсан, хэлсэн бүх санал дээр бол би эргэж нэг бүрчлэн анализ хийж ажиллаж та бүхэндээ хувь гишүүнд нь болон холбогдох Байнгын хороон дээр танилцуулж ажиллана гэж ингэж төсөөлж байна. Тэр аудитын цар хүрээ бол нэмэгдэж байгаа гэдэг нь үнэхээр тийм байгаа. Өөрөөр хэлбэл төсөв нэмэгдэх тусам төсөвт байгууллагууд сургууль цэцэрлэг ч гэдэг юм уу баригдах тусам л аудитын ажлын цар хүрээ нэмэгдэж байгаа. Тийм учраас тэр болгонд хүрч ажиллах тийм оноо оновчтой тийм арга зам зохион байгуулалтыг л сонгох ийм асуудал байж байгаа.

Тийм учраас одоо байгаа орон тоо, бүтэц зохион байгуулалт бүх зүйл бол саяын хүрч ажиллах чиглэлд бол зөв тооцоологдож, хуваарилагдаж ажиллах ёстой болов уу. Энэ чиглэлд би хэрвээ томилогдвол холбогдох зохион байгуулалт юмаа анхаарна гэж ингэж бодож байгаа. Баянхонгорт баригдаж байгаа тэр ХАА-тай холбоотой асуудлыг хэрвээ баригдаж байгаа бол тухайн төсвийн захирагчдаараа дамжаад бол жил болгон тайлагналтад ороод явж байх ёстой. Баригдаад

дуусчихсан тодорхой байгууллага бол энэ дээр мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын энэ үр дүнг аудит хийх бололцоотой байгаа. Энэ тал дээр би нарийвчилж судлаад би танд бололцоо шийдлүүдийн хувилбаруудыг танд тусгайлаад танилцуулъя гэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Өнөөдөр Монголын хүүхдийн байгууллагын 100 жилийн ой болж байгаатай холбогдуулаад хүүхдийн байгууллагын төлөөлөл болсон хүүхдүүд парламентын үйл ажиллагаатай танилцахаар орж ирсэн байна. Дүү нартаа баяр хүргэе ээ. Жуковын Алдаржавхлан гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ж.Алдаржавхлан: Магнайсүрэн даргыг мэднэ. Төрийн албанд олон жил ажиллаж байгаа. Төрийн албаны мерит зарчмаар явж байгаа, дэмжиж байгаа. Гэхдээ Магнайсүрэн даргаа 2 асуулт байна.

Нэгдүгээрт та Үндэсний аудитын газар очоод одоо байгаа бүтэц бүрэлдэхүүнээр төрийн аудитын бүх үйл ажиллагааг явуулна гэхэд эргэлзээтэй байгаа юм. Тийм учраас одоо байгаа бүтэц бүрэлдэхүүнээ аль болох энгийн хэлбэрт оруулж хувийн хэвшлийн аудитуудыг ашиглах тэд нарыг өргөнөөр дэмжих ажлыг судалж үзээсэй гэж би та бүхэнд танд хүсэж байгаа юм. Бид нар хувийн хэвшлийнхээ аудитын байгууллагыг дэмжиж хөгжүүлэх ёстой тийм ээ. Энэ чиглэлээр ажиллаасай гэж 1 дүгээрт хүсэж байна.

Хоёрдугаарт би танай өмнөх даргад нэг ийм хүсэлт явуулаад одоо хүртэл хариу өгөхгүй байгаа юм аа. Энэ Удирдлагын академи гээд нэг ийм статус нь ойлгомжгүй байгууллага байдаг юм. Нэг харахаар сургууль ч юм шиг нэг харахлаар ТӨК ч юм шиг. Нэг гараараа оюутнуудаас төлбөр авдаг, нөгөө гараараа улсын төсвөөс татаас авдаг. Тэгээд ийм байгууллага байгаа. Тэгээд энэ байгууллагын статусын асуудлыг нь нэг тийш нь болгож өгөөч. Энэ байгууллага дээр аудитын хийж өгөөч гэсэн хүсэлтийг би танай өмнөх дарга нар тавьсан. Тэгээд алга болсон. Айсан юм уу яасан юм алга болсон. Яагаад гэвэл тэр байгууллага маань өнөөдөр санхүүгийн томоохон зөрчилд орчихсон байгаа гэсэн мэдээллийг тэр доторх ажилтан албан хаагчдаас байнга өгч байгаа. Сард 56 сая төгрөгийн цалинтай захирал байсан байж байгаа. Төсвийн сахилга батыг маш ихээр зөрчсөн ийм асуудал үүссэн. Тийм учраас та очоод энэ Үндэсний аудитын газраас энэ Удирдлагын академи гэдэг байгууллагын статусын асуудал дээр нэг аудит хийж өгөөч. Тэгээд ер нь тэр төрийн албаны мэргэшүүлэх гэж байгаа юм заавал тэр дарга бэлдэх дамжаа байх албагүй гэж би үзэж байгаа юм.

Нэр нь хүртэл удирдлагын гэсэн. Зөвхөн дарга нарт зориулсан тийм академи байгаа байхгүй юу. Энийг төрийн албыг мэргэшүүлэх эсвэл тийм академи болох ёстой. Эс үгүй бол өөрийнхөө сургалтын төлбөрөө үйл ажиллагаа явуулдаг МУИС шиг сургууль болох ёстой. Энэ чиглэлээр та бас тодорхой арга хэмжээ авч өгөөч гэдэг ийм хүсэлт энд хариулт авчихъя аа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

С.Магнайсүрэн: Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя.

Ер нь хүний хүчээр бүгдэд хүрч ажиллахад хүнд гэдэг нь ойлгомжтой. Ер нь юмнууд үзэж харж байхад тодорхой харагдаж байна лээ. Тэгэхээр энд бол 2 асуудал байгаа.

Нэгдүгээрт бол орчин үеийн шинжлэх ухаан дахь техник технологийн ололт цахим инновацын асуудлыг бол нэг ашиглаж, үйл ажиллагаандаа ашиглах асуудал. Нөгөө талаар таны хэлдэгчлэн хувийн хэвшлийн аудитын байгууллагатай хамтарч ажиллах ийм асуудлууд аль аль нь зэрэгцэж яригдана. Яригдах ёстой байх. Өнөөдрийн байдлаар хувийн хэвшлийн аудитын тусгай зөвшөөрлийг бол Сангийн яам буюу сангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу олгодог. Мөн надад байгаа мэдээллээр бол нэг 60 орчим байгууллага байдаг юм байна гэсэн ийм мэдээлэл авсан. Энэ байгууллагуудыг чадавхжуулахаас авхуулаад аудитынх нь үр дүн чанар хүртээмжийг нь дээшлүүлэх асуудал бас гишүүд зэрэгцэж санал ярьж байгаа.

Тийм учраас аль аль талд нь анхаарна. Энэ байгууллагуудаа туршиж, хамтарч ажиллах, мөн энэ байгууллагуудаа аудитынх нь чанар үр дүнгийн хүртээмжийг нь нэмэгдүүлэх асуудал гээд тал бүрээс нь анхаарч хамтарч ажиллах ийм тал дээр явах байх гэсэн ийм зүйлийг би хэлэх байна.

Удирдлагын академитай холбоотой асуудлыг мэдээж одоо төрийн болон төсөвт байгууллага төрийн болон төрийн өмчийн аудитын оролцоотой бүх л газрууд аудит хийлгэдэг учраас энэ байгууллага дээр аудит хийгдсэн байж таарна. Энэ асуудлыг би очиж хэрвээ томилогдох юм бол үзээд танд би тусгайлаад энэ талаар мэдээлэл өгье.

Шаардлагатай бол энэ тал дээр эргэж ямар гарц шийдлүүд байна гэдгийг хэлье гэж ингэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Жанчивын Галбадрах гишүүн асуулт асууя, үг хэлье.

Ж.Галбадрах: Өдрийн мэнд. Би нэр дэвшигч Магнайсүрэнг сайн мэдэхгүй. Тэгэхдээ анкет тэр шалгуурыг нь хараад бол бүрэн дэмжиж байна аа. Үндэсний Аудитын газар бол танай байгууллага бол Улсын Их Хурлын гишүүд, олон нийт хэвлэл мэдээллийг үнэн зөв бодитой тийм мэдээллээр хангах үндсэн үүрэгтэй байгууллага. Хараат бусаар ажиллах ёстой үүнийг Ерөнхий Аудит та бол манлайлж ажиллах ийм үүрэгтэй хүн. Тэгээд танай байгууллагыг би бодлогын аудит хийдэг болоосой гэж ингэж хүсэж байгаагаа 1 дүгээрт хэлмээр байна. Олон гишүүд хэлж байна. Энэ ТӨК-уд дээр хийдэг аудитыг бодлого гаргаад бүр тэнд хийдэг аудитыг яаж хийх вэ гэдэг энэ зарчмыг гаргаасай гэж бодож байна. Нөгөө талаас үүнтэй зэрэгцээд жишээлбэл боловсролын салбарт сургууль, цэцэрлэг тэрний барилга байгууламж барьж байгаа энэ дээр хийдэг энэ аудит дээр бас бодлого бариасай. Ялангуяа ирэх жил 2026 он маань боловсролыг дэмжих жил болж байгаа. Бид нар олон сургууль, цэцэрлэгийг шинээр барихаар оруулсан байгаа. Энэ дээр нэг аудитын дүгнэлт үнэлгээнүүд маань зарим талаар саад болдог, зарим талаар ажлыг зогсоодог ийм зүйлүүд рүү ордог. Тэгэхээр энэ дээр нэг бодлогын аудит хийх тал дээр анхнаасаа анхаараасай гэж танд хэлмээр байна. Тэгээд аудитын байгууллагын маань гол бүтээгдэхүүн бол аудит хийх тайлан гаргах гэж ойлгож байгаа.

Тэгэхээр хэрвээ та томилогдвол бүтцээ маш сайн зөв өөрчлөх хэрэгтэй. Бас гишүүд хэлээд байна. Тэгээд олон дарга нараа цөөлөх хэрэгтэй л гэж би шулуухан хэлмээр байна. Бас ингээд бүтцийг нь хараад ингээд үзэхэд маш олон даргатай байдаг юм байна лээ. Аудит хийдэг хүмүүсээ харин сайн нэмэгдүүлээрэй. Тэр

хүмүүс маш их ажлын ачаалалтай ажилладаг юм байна лээ. Тэгэхээр тэр ажлын ачааллыг нь багасгах, бодлоготой, алдаа мадаггүй, зөв үнэн зөв хийх тал дээр нь энэ маш их ач холбогдолтой болно гэж хэлж байна. Мөн хувийн аудитын байгууллагуудтай хамтарч ажиллах энэ тал дээрээ бас бодлого гаргаж ажиллаарай гэдгийг хэлмээр байна. Тэгээд аудит хийдэг газруудаа л бэхжүүлэх гэдэг нь энэнтэй холбогдуулаад би 2 асуулт асууя гэж ингэж бодож байна.

Аудитын байгууллагаас ирүүлсэн олон алдаа, зөрчил, төрийн байгууллага болон төрийн компаниуд бүх л зүйлүүд энэ шийдвэрүүд гарч ирдэг. Тэгээд үүнийг бол харин төсвийн захирагч нар маань бүрэн хэрэгжүүлэхгүй байгаа учраас алдаа зөрчил энэ завхрал маань давтагдаад явсаар байгааг та үүнийг яаж засах вэ? Түрүүн бас хэлж байна шүү дээ. Бүүр алдаатай гэж гарч ирсэн мөртөө дарга нь жинхлээд яваад өг дөө гэдэг шиг. Тэгвэл энэ талаар төлөвлөсөн ажил байна уу гэдгийг 1 дүгээрт асууя.

Хоёрдугаарт аудитын байгууллага бол сүүлийн үед төрийн захиргааны байгууллага шиг болсон байна. Үүнийг яаж засах вэ танд ямар бодлого төлөвлөгөө байна вэ гэдэг ийм 2 асуулт асууя аа. Баярлалаа. Танд амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Лхагвын Мөнхбаатар гишүүн. Аан за асуултад хариулъя. Магнайсүрэн дарга хариулъя.

С.Магнайсүрэн: Галбадрах гишүүний асуултад хариулъя.

Үндэсний аудитын газар хуульд заасны дагуу чиг үүргээ гүйцэтгээд санхүүгийн тайлангийн аудит, гүйцэтгэлийн аудит, нийцлийн аудит гэсэн ийм 3 төрлийн аудит хийгээд олон дүгнэлт зөвлөмжүүдийг гаргаж ингэж холбогдох байгууллагуудад хүргүүлж хэрэгжилтийг нь тооцож ажилладаг.

Зөвхөн 2024 онд гэхэд сан 6930 байгууллагын хэмжээнд энэ санхүүгийн тайлангийн аудитын баталгаажуулалт хийгддэг байх жишээтэй. Тэгэхээр зөвхөн 2024 онд хийгдсэн аудитын үр дүнгээр юу илэрсэн бэ гэхээр зэрэг 7.3 их наяд төгрөгийн зөрчил дээр 9629 зөвлөмж өгсөн гэж байгаа юм. Тэгээд албан шаардлага бол бараг 33 их наяд төгрөгийн хэмжээнд албан шаардлага өгсөн. Төлбөрийн актыг болохоор зэрэг мөн багагүй хэмжээний юун дээр төлбөрийн акт тавьсан. Тухайлах юм бол 2024 онд 76.3 тэрбум төгрөгийн төлбөрийн акт тогтоосон гээд. Тэгэхээр энэ бүх тоон мэдээ юу харуулж байна вэ гэхээр зэрэг хамгийн гол нь энэ аудитаа хийчхээд дараа нь үүнийхээ үр дүнгээр энэ хэрэгжилтийг нь хангах асуудал аягүй чухал юм байна гэдэг нь бол өчигдрийн Байнгын хорооны хурал болоод гишүүд та бүхний хэлж байгаа саналаас тодорхой харагдаж байгаа.

Тийм учраас энэ хэрэгжилтийг хангах асуудал дээр онцгойлон анхаарч ажиллана. Дээр нь Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу сахилгын хариуцлага хүлээлгэх болон ажлаас халах гэсэн ийм 2 төрлөөр хариуцлага хүлээлгэхээр хуульд заагдсан байна лээ. Энэ хариуцлагын хуулийн зохицуулалтуудын хэрэгжилтийг ч гэсэн хангахад би онцгой анхаарч ажиллана гэж ингэж хэлэх байна.

Аудитын байгууллага захиргааны байгууллага шиг болсон гээд та хэллээ. Түрүүн би нэг хариултдаа хэлсэн байгаа. Ер нь бол Төсвийн байнгын хорооноос хэд хэдэн удаа нэмэгдсэн орон тооны бас нэлээд нь захиргаа чиглэл рүүгээ томилогдчихсон, томилогдсон юм байна лээ гэсэн ийм шүүмжийг өмнөх сонсгол юун

дээр гишүүд хэлсэн учраас би энийг очсон тохиолдолд судалж байж энийг ачааллыг нь тааруулаад тэр мэргэжлийн чиг үүрэг ажлаа хийх тал руу нь энэ бүтэц юм бол чиглэгдэх ёстой гэдэг нь ойлгомжтой зарчим. Хууль нь ч тийм байгаа. Тийм учраас энэ дагуух асуудлыг бол шийдэх бололцоотой гэж ингэж харж байна аа.

Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Лхагвын Мөнхбаатар гишүүн асуулт асууж, үг хэлье.

Л.Мөнхбаатар: Нэр дэвшиж байгаа Магнайсүрэн өчигдөр Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу олон нийтийн сонсголоор орж сонсголд асуулт хариулт явагдаж дэмжигдсэн. Төсвийн байнгын хороогоор ингээд дэмжигдээд ороод ирж байгаа. Өчигдрийн сонсгол дээр үг хэлж байгаа гишүүдийн хувьд ч тэр өнөөдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд үг хэлж байгаа гишүүдийн байдлаас хэлэлцүүлгийн явцаас харахад бол Магнайсүрэнг төрийн ажлын албаны дадлага туршлагатай хараат бусаар ажиллаж чадах шалгуур хангасан хүн гэж ихэнх нь дэмжиж байх шиг байна. Нэлээн магтаалын үгтэй дэмжигдэхээр байна аа.

Тийм учраас Улсын Их Хурлын зүгээс ч гэсэн олон нийтийн зүгээс өөрт чинь нэлээн их дэмжлэг байгаа. Энийгээ үүний цаана хариуцлага байгаа гэдгийг санаж ажиллах нь зүйтэй байх гэж би бодож байгаа юм. Ер нь аудитын байгууллага гэдэг бол ер нь 3 зарчим дээр л тулгуурладаг. Аудитын үйл ажиллагаа бол хараат бус байх ёстой, ил тод байх ёстой, бие даасан байх ёстой ийм л 3 зарчим байгаа юм. Энэ дотроо энэ хараат бусаар ажиллах энэ зарчмыг бол талаар гишүүд их олонтой ярьсныг үйл ажиллагаандаа сайн хэрэгжүүлж энэ чиглэлээр сайн мөрдөж ажиллах хэрэгтэй. Нөгөөдөх нь ил тод байдал байгаа юм. Аудитын тайлан мэдээллүүдэд шийдвэрүүд гардаг олон шийдвэрүүд гардаг. Эдгээр тайлан шийдвэрүүдийг л ил тод болгож иргэд олон нийт энэнтэй танилцдаг бүгд мэддэг байгаад ирэх юм бол энэ хэлбэрүүдийг нь сайн өөрчлөх хэрэгтэй. Ингэх юм бол ерөөсөө аудитын байгууллагын үйл ажиллагаа, тайлан, мэдээлэл, шийдвэрүүдтэй танилцаад ирэх юм бол угаасаа, энэ чиглэлээр, төсөвт байгууллага, төрийн байгууллагуудын энэ хяналт шалгалтад бол энэ иргэдийн оролцоо аяндаа нэмэгдээд ирнэ. Энэ дээр онцгойлон анхаарах хэрэгтэй.

Нөгөөтээгүүр аудитын байгууллагын учир дутагдалтай хийж ирсэн нэг ажил бол энэ Шилэн дансны тухай асуудал байгаа юм. Ер нь төсөвт байгууллага төрийн байгууллагын санхүү төсвийн үйл ажиллагаанд хяналт тавих гол зүйл бол Шилэн дансны тухай хуулиар хэрэгждэг. Энд хэрэгжих ёстой. Энэ хуулийн хэрэгжилтийг хэн хангах ёстой вэ гэхээр аудитын байгууллага хангах хуулиар хүлээсэн үүрэгтэй. Гэтэл одоо шилэн Цогоо л энэ ажлыг л одоо өмнөөс нь хийгээд яваад байгаа. Ер нь бол шилэн Цогоод аудитын байгууллага цалин өгөх хэрэгтэй байгаа шүү. Ер нь бол.

Тийм учраас энэ чиг үүргээ хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарах хэрэгтэй. Ил тод байдлыг чинь л та бүгдийн ажлын нэг үндэс болно. Том зарчим чинь байгаа юм.

Хоёр дахь нэг зүйл энэ аудитыг хараат бусаар ажиллуулахад энэ мэдээллийн технологи, хиймэл оюун ухааныг ашиглах ажлыг яг танай байгууллагаас эхэлбэл хамгийн үр дүнтэй болно гэж хараад байгаа юм Магнайсүрэн дарга аа.

Яагаад гэвэл ерөөсөө энэ аливаа нөлөөлөлд орохгүйгээр эрсдэлгүй ийм шийдвэр гаргахад бол нь аудитын чанар үр нөлөөг дээшлүүлэхэд энэ хиймэл оюун ухааныг ашиглах юм бол нь хамгийн үр дүнтэй болох салбар гэж үзэж байгаа юм.

Тийм учраас энэ чиглэлээр та нэлээн ач холбогдол өгч энэ чиглэлээр танай байгууллага ажиллах ёстой шүү гэж үзэж байгаа юм. Ер нь Эстони гээд олон улсууд энэ чиглэлээр их үр дүнтэй ажиллаж байгаа шүү дээ. Хамгийн боломжтой мэдээллүүдээ материалуудаа оруулчихдаг энд нь аудит бол болбол тодорхой хэсгүүдийг нь бол нь үнэлээд гаргаад ирнэ. Энэ дээр хүний оролцоо багатай ингээд явах боломжтой салбар шүү гэдгийг та бүгдэд хэлье гэж бодож байна. Яагаад гэвэл энэ мэдээллийн дүн шинжилгээ дээрээ л гол сууриалаад явдаг ажил байгаа юм. 3 дахь зүйл бол энэ боловсон хүчнийхээ асуудал дээр та бүхэн анхаараарай.

Ерөнхийдөө мэргэшсэн нягтлан бодогчид ер нь манай аудитад байгаад байдаг. Гэтэл та бүгдийн хийж байгаа аудит хийж байгаа хүрээ хязгаар их өргөн байгаад байгаа шүү дээ. Маш олон том төслүүд Оюу Толгойгоос эхлээд том төслүүд дээр хийхэд энд олон улсын чиглэлээр мэргэшсэн хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн маш олон чиглэлээр мэргэшсэн ийм боловсон хүчнүүд шаардлагатай байгаа гэдгийг бас хэлэх нь зүйтэй. Мөн таны өмнөх удирдлагаар ажиллаж байсан Загджав дарга бол энэ ажиллах хугацаандаа энэ гүйцэтгэлийн аудитыг сайжруулах, гадаад харилцаагаа сайжруулах, аудитынхаа олон чиглэлийн ажлуудыг нэлээн сайн гүйцэтгэсэн эдгээр ажлуудыг нь үргэлжлүүлж ажиллах нь зүйтэй гэдгийг танд хэлье гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Жаргалан: Сайн байцаана уу? Улсын Их Хурал ард түмний төлөөлөл. Тэгэхээр та бид ямар ч, аль ч намаас сонго нэр дэвшиж сонгогдсон бай нэгэнт тангараг өргөсөн бол иргэдийнхээ эрх ашгийн төлөө ажиллаж, эх орныхоо эрх ашгийн төлөө бодлого шийдвэр гаргаж хяналт тавих ёстой. Тэгээд энэ аудитын байгууллага бол Улсын Их Хурлын харьяа байгууллага, тэр утгаараа ч тэр Улсын Их Хурлын нүд чих нь болох ёстой. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тэр чиг үүрэгт хамгийн их дэмжлэг туслалцаа үзүүлэх тэр алдаа дутагдлыг илрүүлж байх ёстой.

Тэгээд өнгөрсөн хугацаанд бол бид Улсын Их Хурлаас томилогдож байгаа хэд хэдэн хүмүүсийг бол нэр дэвшигч нарыг томилж явууллаа. Тэгээд өмнөх нэр дэвшигч нарын тухайд ч тэр одоо орж ирж байгаа нэр дэвшигчийн тухайд ч тэр улсад тэдэн жил ажилласан байна, энэ байгууллагадаа тэдэн жил ажилласан байна энэ маш сайн үзүүлэлт. Туршлага сайтай хүн байна гээд л энэ танхимд орж ирцгээгээд гишүүд нь магтаад байх юм. Гэтэл өнгөрсөн энэ 30 жилд бий болсон алдаа завхралыг хэн бий болгосон юм бэ? Ер нь энэ төрийн албанд олон жил ажилласан аль нэг байгууллагад олон жил ажилласан гэдэг чинь сайн үзүүлэлт гэхээсээ илүү бараг сөрөг үзүүлэлт болчихоод байна шүү дээ. Энэ нь бид нарын шинэ 30 жил, энэ шинэ 126 гишүүнтэй парламентын бий болгох гээд байгаа өөрчлөлт бол энэ өмнөх 30 жилийн алдаа завхралыг засах гээд байгаа гэж ойлгож байгаа. Гэтэл тэр бүх зүйл дээр хэд 3 яам дамжаад ТНБД хийчихсэн. Тэр бүх бодлого шийдвэр дээр байсан хүнийг орж ирэхлээр нь туршлага сайтай хүн гээд байгаа г би бол хувьдаа ойлгохгүй байгаад байна.

Бид нарт ийм шинэ санаа хэрэгтэй байна. Цоо шинэ арга барил хэрэгтэй байна. Асуудлыг ийм өөр өнцгөөс шинэлэг байдлаар харах тийм боловсон хүчин хэрэгтэй байна гэж бодоод байгаа юм. Тэгэхээр Их Хурлын гишүүддээ уриалмаар байгаад байгаа юм. Хэдүүлээ энэ хайрцагаасаа бас жаахан гаръя аа. Яг ард түмний төлөөлөл байх, ард түмний нүд чих нь байх тэр үүргээ гүйцэтгэхдээ анхааръя аа.

Тэр утгаараа энэ аудитын томилгоо бол та бидний хувьд хамгийн чухал томилгоо юм аа. Тэр хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэх хамгийн тийм чухал томилгоо байгаад байна аа. Тэгээд одоо энэ хувийн хэвшилд жишээлэх юм бол хувийн аудитын байгууллагад ажиллахын тулд эрх авахын тулд аудитор болохын тулд мэргэшсэн нягтлан бодогч болохын тулд маш өндөр шалгууруудыг даван туулаад олон удаагийн шалгалтаар орж ирээд тэгээд эрхээ авдаг аа. Гэтэл Монгол Улсын Ерөнхий аудитор эрх зүйч хүн нэр дэвшээд явж байна танд тэгэхээр одоо эрх зүйч хүний хувьд энэ Монгол Улсын Ерөнхий аудитор гэдэг энэ том албан тушаал дээр энэ яг мэргэшсэн албан тушаал дээр ажил үүргээ гүйцэтгэх итгэл үнэмшил байна уу гэж 1 дүгээрт асуумаар байна.

Хоёрдугаарт аудитын байгууллагын үе үеийн дарга нар улс төрийн бас харилцаа хамаарал бүхий ажлаа өгөөд улс төрийн сонгуульд нэр дэвших зорилго зорилт агуулсан иймэрхүү зүйлүүд ажиглагдаж байсан.

Та өнгөрсөн хугацаанд аль нэг улс төрийн намын гишүүнчлэлтэй байсан уу? Ер нь цаашид ийм улс төрийн сонгуульд нэр дэвших ч гэдэг юм уу тийм амбиц бодол байгаа юу? Хараат бус ажиллах чадвар байгаа эсэхдээ хэр их итгэлтэй байна вэ гэдэг ийм асуултууд байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

С.Магнайсүрэн: Жаргалан гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулаад энэ төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж ингэж хуульчлаад энэний дагуу 2020 онд Төрийн аудитын тухай хууль батлагдан гарсан. Энэ хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль дээр бол Ерөнхий аудиторовын тавих шаардлага нь эдийн засаг санхүү эсхүл эрх зүйч мэргэжилтэй байх, тэгээд 45 нас хүрсэн байх, төрийн албанд ажиллаад ажилласан эрхэлсэн түшмэлээс дээш 10 жилээс дээш ажилласан байх ийм шалгуурууд тавигдсан. Мөн таны саяын хэлсэнчлэн сүүлийн 6 жил улс төрийн идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй байх. Улс төрийн намын гишүүнчлэлийн асуудлыг тавьсан байдаг. Ийм шалгууруудтай юм билээ. Тэгээд миний хувьд бол энэ шалгуурыг тодорхой түвшинд хангаж байгаа гэдэг үндэслэлээр ингэж нэр дэвшигч гэж орж ирсэн байгаа.

Зүгээр ер нь Аудитын хууль, аудит бол үндсэндээ санхүүгийн тайлангийн аудит, гүйцэтгэлийн аудит, нийцлийн аудит гээд ингээд 3 төрлөөр аудит хийж байгаа. Энэ 3 гурвуулаа чухал. Тэгэхээр нийслэлийн болон гүйцэтгэлийн аудит бол үндсэндээ хуулийн хэрэгжилт, хууль тогтоомжийн бодлого, хууль дүрэм, стандартын хэрэгжилтийг л шалгадаг. Ийм чиглэлээр үндсэн чиглэл нь явж байгаа. Тэгэхээр бол эрх зүйчийн хувьд бол энэ чиглэлээр ажиллах асуудал дээр ямар нэгэн харшлах шалтгаан байхгүй.

Дээр нь бол үндсэндээ аудитын үндсэн чиг үүрэг бол хууль тогтоомжийн хэрэгжилтийг ялангуяа төсөв санхүүгийн хууль тогтоомж болоод бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж байгаа гэдгээрээ бол ажиллах бүрэн бололцоотой гэж ингэж үзээд нэр дэвшиж байгаа юм аа? Улс төрийн намын гишүүнтэй холбоотой сая би хэллээ. Сүүлийн 6 жил энэ шаардлагыг бүрэн хангаж байгаа. Би бол төрийн алба хашаад өнөөдрийг хүрсэн учраас тийм намын юу байсангүй.

Хоёрдугаарт бол өмнө нь ч энэ сонгуульд орохоор ч юм уу энэ чиглэлээр ямар нэгэн асуудал хийж ажлаа өгөөгүй өнөөдрийг хүртэл бол ажиллаж ирсэн.

Тийм учраас энэ сонгуультай холбоотой асуудлаар тийм зүйл байхгүй гэж ингэж хариу хэлэх байна.

Хараат бусаар ажиллах гэдэг бол аудитын байгууллагын үндсэн зарчим мөн чанар нь. Тийм учраас энэ олон улсын тунхаглалд заасан ч гэсэн манай хууль Үндсэн хуульд заасны дагуу хараат бусаар ажиллах ёстой асуудал бол чухал учраас зөвхөн Ерөнхий аудитор нь хараат хараат бус байхаас илүүтэй тухайн байгууллага байгууллагын өөрийнх нь ажилтнууд хараат бус байх ёстой. Энэ 1 дүгээрт хууль эрх зүйн орчин нь хараат бус байлгах эрх зүйн үндсийг тогтоосон байх.

Хоёрдугаарт нь одоо эдийн засгийн болоод бусад баталгааны хувьд хараат бус байх гээд олон асуудлуудыг бол шийдсэн байгаа. Тэгээд энэ хүрээнд.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2-т нэгдсэн хуралдаан эрх бүхий албан тушаалтны санал, холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, нууц санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх томилох, чөлөөлөх саналыг дэмжсэн бол энэ тухай тогтоол баталсанд тооцно гэж заасан. Үүний дагуу нууц санал хураалт явуулна аа.

Байнгын хорооны саналаар Сандагийн Магнайсүрэнг Монгол Улсын Ерөнхий аудитораар томилох саналыг дэмжье гэсэн. Саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Нууц санал хураалт.

75 гишүүн буюу 80.6 хувиар дэмжигдлээ.

Монгол Улсын Ерөнхий аудитораар томилох саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монгол Улсын ерөнхий аудиторыг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Ерөнхий аудитораар томилогдсон Магнайсүрэн даргад ажлын амжилт хүсье.

Улсын Их Хурлын гишүүд өнөөдөр аудитын байгууллагын талаар онцгой анхаарал хандуулж үгээ дайж хэллээ. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай

хуулийн хэрэгжилтийг хангалттай түвшинд байлгах нөхцөлийг бүрдүүлдэг гол байгууллагын нэг бол аудитын байгууллага. Аудитын байгууллага Улсын Их Хурлынхаа нүд чих нь байж гүйцэтгэх засаглалын түвшинд гарч байгаа санхүүгийн болон гүйцэтгэлийн олон алдаа дутагдлыг илрүүлж хариуцлага тооцож чаддаг хэмжээнд үйл ажиллагаагаа авч явах зайлшгүй шаардлагатай. Ард иргэдийн зүгээс хүсэж байгаа хяналт шалгалтын чиг үүргийг бодитой ажил хэрэг болгож ажиллаарай гэдгийг Улсын Их Хурлаас чиг үүрэг өгье.

Аудитын байгууллагын бүтэц бүрэлдэхүүнтэй холбоотой асуудал сүүлийн жилүүдэд өргөжиж томорсон гэдэг шүүмжлэлийг Улсын Их Хурлын гишүүд хэлж ярьдаг. Тэгээд үүнтэй холбогдуулаад аудитын байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнтэй холбоотой асуудлыг судалж Улсын Их Хурал, Төсвийн байнгын хороонд танилцуулж ажиллах үүрэг чиглэлийг өгье өө.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын Ерөнхий аудиторовын үүрэгт ажлаас чөлөөлөх нууц санал хураалтыг явуулна аа.

Бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Дэлэгийн Загджавыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна аа.

Нууц санал хураалт.

60 гишүүн буюу 64.5 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монгол Улсын ерөнхий аудиторовын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

“Монгол Улсын ерөнхий аудиторовыг томилох тухай”, “Монгол улсын ерөнхий аудиторовыг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг уншиж танилцуулъя аа.

Монгол Улсын ерөнхий аудиторовыг томилох тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Сандагийн Магнайсүрэнг Монгол Улсын Ерөнхий аудитораар томилсугай.

2.Энэ тогтоолыг 2025 оны 5 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Дараагийн тогтоол

“Монгол Улсын ерөнхий аудиторовын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, Төрийн аудитын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тул Дэлэгийн Загджавыг Монгол Улсын ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2025 оны 5 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

“Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох тухай”, “Монгол Улсын Ерөнхий аудиторыг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье.

11.40 цагт

Дараагийн асуудалд оръё. [Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 4 дүгээр дүгнэлтийг хэлэлцэнэ.](#)

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Бямбадоржийн Болдбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 4 дүгээр дүгнэлтийг танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн холбогдох заалт, Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай. Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим. 11 цаг 30 минут.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан даргалж, гишүүдэд Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ж.Эрдэнэбулган, Д.Гангабаатар, О.Мөнхсайхан, Б.Болдбаатар нарын бүрэлдэхүүнтэй хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гомдол гаргагч иргэн Н.Туяа оролцлоо. Энэхүү хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт тойрогт ногдсон мандатын тооноос дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно гэж заасны “дутуу” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд чөлөөтэй сонгох эрхийн үндсэн дээр сонгоно гэснийг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 4 дүгээр дүгнэлт нь нийт 15 нүүр түүний үндэслэх хэсэг нь 11 нүүр болсон тул та бүхэнд дүгнэлтийн үндэслэх хэсгийг товчилж тогтоох эсэхийг бүхэлд нь уншиж сонсгоё.

Үндэслэл.

1.Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэг заалт 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Их Хурлын гишүүнийг иргэд нийтээрээ, чөлөөтэй, тэгш, шууд сонгох, саналаа нууцаар гаргах зэрэг ардчилсан сонгуулийн зарчмыг хамгаалсан болно оо. Эдгээр зарчим нь сонгогчдын хүсэл зоригийн чөлөөт илэрхийллийг баталгаажуулж ардчилсан сонгууль явуулах суурь нөхцөлийг тогтоож өгдөг.

Саналаа нууцаар гаргах зарчмын гол зорилго нь сонгох чөлөөтэй сонголт хийх нөхцөлийг бүрдүүлж, улмаар сонгуулийн дүн, сонгогчийн хүсэл зоригийн жинхэнэ илэрхийлэл байх баталгааг хангах юм аа. Нөгөө талаас сонгогч тодорхой нам, эвсэл, нэр дэвшигчид санал өгөхгүй байх эрх нь чөлөөт сонголтын нэг хэлбэр мөн. Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан чөлөөтэй сонгох зарчим нь нэр дэвшигч нам, ёслолыг дэмжих эсэх, эсвэл сонголтоо хараат бусаар хийх, саналын хуудас тэмдэглэх боломжийг сонгогчдод олгох, уг сонголтыг нь хүндэтгэх агуулгыг илэрхийлнэ. Тодруулбал сонгогч аль нэг нэр дэвшигч нам, эвслийг дэмжих, эсвэл дэмжихгүй байх саналаа чөлөөтэй өгөх бөгөөд энэ эрхээ эдлэхтэй нь холбогдуулан сонгогчийг албадлага, дарамт, сүрдүүлэг, эсхүл зүй бус нөлөөлөлд оруулж болохгүй. Уг зарчим нь зөвхөн саналаа өгөх эрхээр хязгаарлагдахгүй бөгөөд сонгуулийн бүх үйл явцыг хамаардаг аа.

Маргаан бүхий зохицуулалт нь сонгогч тойрогт ногдох мандатын тооноос цөөн нэр дэвшигчийг дэмжих сонголтоо хэрэгжүүлэхийн тулд мандатын тоотой тэнцүүлж санал өгөх, улмаар өөрийн дэмжихгүй нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэхээс өөр аргагүйд хүргэхээр байна аа. Өөрөөр хэлбэл сонгогч нэр дэвшигчийн талаар чөлөөтэй сонголт хийх, саналаа тэмдэглэх боломжийг хязгаарлажээ. Түүнчлэн тойрогт ногдсон мандатын тооноос дутуу тэмдэглэсэн саналын хугацааг хүчингүйд тооцсоноор тухайн сонгогчийн санал гээгдэж тэнцсэн нэр дэвшигчийн төлөө өгсөн саналыг тоолохгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна аа. Нөгөө талаас энэ нь тухайн сонгогчийн дэмжлэгийг хүлээгээгүй нэр дэвшигч үндэслэлгүйгээр нэмэлт санал авах, зүй бус давуу байдал олгох үр дагавартай.

Тиймээс уг зохицуулалт нь сонгуулийн дүн, сонгогчийн хүсэл зоригийн бодит илэрхийлэл байх нөхцөлийг алдагдуулах эрсдэл үүсгэж чөлөөтэй сонгох эрхийг хязгаарласан байна.

2.Монгол Улсад туйлын эрхээс бусад үндсэн эрхийг хязгаарлаж болох ч хууль хязгаарлалт нь эрх зүйн тодорхой байдалд тохирсон байх ялгаварлан гадуурхаагүй байх зэрэг зарчмыг хангахыг Үндсэн хуулиар шаардах бөгөөд аль нэг зарчмыг нь хангаагүй бол тухайн хязгаарлалт нь үндсэн эрхийг зөрчсөн үндэслэл болно. Сонгох сонгогдох эрх нь туйлын эрх биш тул зөвхөн эдгээр зарчмыг хангасан хязгаарлалтыг хуульчлах боломжтой.

2.1.Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгээр баталгаажсан хууль дээдлэх ёсны хүрээнд үндсэн эрхийг гагцхүү хуульд тодорхой заасан үндэслэл журмын дагуу хязгаарлаж болно. Эрх зүйн тодорхой байдлыг хангах хүрээнд үндсэн эрхийг гагцхүү хуулиар хязгаарлах. Уг хязгаарлалт нь хоёрдмол утгагүй, тодорхой ойлгогдохоор, зохицуулалтаас үүдэх үр дагаврыг урьдчилан таамаглах, сахин биелүүлэх боломжтой байдлаар хуульчилбал зохино. Үр дүнд нь эрх бүхий этгээд хуулийг нэг мөр хэрэгжүүлж иргэн зан үйлээ хуульд нийцүүлэх нөхцөл бүрдэнэ ээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн холбогдох зохицуулалтыг эрх бүхий этгээд нэг мөр хэрэгжүүлэх, иргэн зан үйлд нийцүүлэх боломжтой гэж үзэхээр байгаа хэдий ч тус хуулийн заалт хоорондын нийцэл алдагдаж, зөрчилтэй байдал үүссэн байх тул эрх зүйн тодорхой байдлыг хангахгүй байна аа. Тодруулбал Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.10 дахь хэсэгт зааснаар нэг ч нэр дэвшигчийн төлөө санал өгөөгүй саналын хуудсыг хүчинтэйд тооцсон атлаа маргаан бүхий зохицуулалтаар тойрогт ноогдсон мандатын тооноос дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцохоор заасан нь хуулийн зохицуулалт хооронд зарчмын хувьд зөрчил үүсгэж, сонгогчийг төөрөгдөлд оруулж болохоор байна аа.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр баталсан аймаг нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд тойрогт ногдох мандатын тооноос дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцохоор заагаагүй байгааг дурдах нь зүйтэй.

2.2. Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн дагуу үндсэн эрхийн хязгаарлалтад тохирсон байх зарчимд нийцсэн байх шаардлагатай. Энэ зарчмын дагуу үндсэн эрхийн хязгаарлалт нь хууль ёсны зорилгод хүрэхэд уялдаатай, зайлшгүй тэнцвэртэй байх гэсэн шалгуурыг хангах ёстой. Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчийн тайлбарт маргаан бүхий зохицуулалтын зорилго нь сонгогч сонгох эрхээ эдлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх явдал гэж тодорхойлсноос үзвэл тухайн зохицуулалт олон мандаттай тойрогт сонгогч хэрхэн саналаа тэмдэглэхийг зохицуулж сонгох эрхээ эдлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготойгоор зорилготойгоо уялдсан гэж үзэхээр байна аа.

Үндсэн эрхийн хязгаарлалт нь хууль ёсны зорилгод хүрэхэд зайлшгүй байх шалгуурыг хангах ёстой. Тус зорилгод хүрэхийн тулд авч болох боломжит үр дүнтэй арга хэмжээнүүдээс ижил үр дүнтэй боловч үндсэн эрхэд хамгийн бага халдсан арга хэмжээг сонгохыг энэ шалгуур шаардана аа. Олон мандаттай тойрогт мандатын тооноос дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэвэл саналын хуудсыг хүчингүйд, эсвэл хүчинтэйд тооцдог гэсэн 2 загвар байх бөгөөд аль аль нь сонгогч саналаа тэмдэглэж сонгох эрхээ эдлэхэд нь дэмжлэг үзүүлэхээр байх боловч эхний загвар нь сонгогч өөрийн дэмжээгүй нэр дэвшигчийн төлөө саналаа тэмдэглэхийг албадах замаар чөлөөтэй сонгох зарчмыг илүү ихээр хязгаарласан байх тул зайлшгүй байх зарчмыг хангаагүй байна аа.

Үндсэн эрхийг хязгаарласнаар хангагдах ашиг сонирхол нь уг эрхийг хамгаалах ашиг сонирхлоос доогуур байж болохгүй. Маргаан бүхий зохицуулалтаар сонгогч бүр тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү нэр дэвшигчийн төлөө саналаа заавал тэмдэглэх үр дагавар үүссэн нь сонгогч тухайн тойрогт ногдох мандатын тооноос дутуу нэр дэвшигчийн төлөө санал өгөх сонголтыг үгүйсгэж, нэр дэвшигчийг дэмжих, эсэхээ шийдвэрлэх боломжийг хумин сонгогчдын хүсэл зоригийн чөлөөт илэрхийллийг гажуудуулах сонгуулийн дүнд нөлөөлөх ноцтой эрсдэлтэй байх тул тэнцвэртэй байх шалгуурт нийцээгүй байна.

2.3. Монгол Улсын Их Хурлын сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгээс ирүүлсэн шинжээчийн дүгнэлт болон Үндсэн хуулийн цэцийн

судалгааны төвийн гүйцэтгэсэн судалгаанаас үзэхэд олон мандаттай тойргийг ашигладаг бусад ардчилсан улсад сонгогч тухайн тойрогт ногдсон мандатын тоотой тэнцүү, эсвэл түүнээс цөөн тооны нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэх эрхтэй бөгөөд сонгогч мандатын тооноос дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн бол саналын хуудсыг хүчингүйд тооцох агуулгатай хэм хэмжээ байхгүй байна.

2.4. Үзэл бодолтой байх эрх нь сонгох эрх ялангуяа чөлөөтэй сонгох эрхтэй салшгүй холбоотой. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь заалтын итгэл үнэмшилтэй байх дотоод эрх чөлөө нь туйлын эрх, харин итгэл үнэмшил үзэл бодлоороо илэрхийлэх эрх чөлөө нь туйлын бус эрх юм аа. Итгэл үнэмшилтэй байх эрх чөлөө нь хүн итгэл үнэмшлээ чөлөөтэй бий болгох, баримтлах, өөрчлөх эрхийг агуулна. Аль нэг итгэл үнэмшил, үзэл бодлыг баримтлах, эсвэл баримтлахгүй байхаар хүнийг албадаж болохгүй.

Гэтэл маргаан бүхий зохицуулалт нь тодорхой нэр дэвшигчийг дэмжихгүй гэсэн сонгогчийн итгэл үнэмшил үзэл бодлыг үгүйсгэж байх тул итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг хөндсөн байна.

3. Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно гэж заасны дагуу холбогдох хуулийг баталж Монгол Улсын Их Хурлын сонгуулийг нийт 9 удаа зохион байгуулжээ. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд тойрогт ноогдсон мандатын тооноос дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцох нь Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг Үндсэн хуулийн цэцээс өмнө нь тухай бүр хянаж түүнийг Үндсэн хуульд заасан сонгуулийн зарчимд нийцүүлэх, боловсронгуй болгох хүрээнд холбогдох шийдвэрийг гаргасан байна.

Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн тойрогт ноогдсон мандатын тооноос дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцох заалтын талаар маргааныг агуулгын хувьд хянан хэлэлцэж Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар шийдвэр гаргаагүй байна.

4. Нэгтгэн дүгнэхэд:

4.1. Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 9 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт нийтээрээ, чөлөөтэй, тэгш, шууд сонгох саналаа нууцаар гаргах зэрэг ардчилсан сонгуулийн зарчмыг баталгаажуулсан нь Монгол Улсын иргэний төрийн байгууллагад сонгох, сонгогдох үндсэн эрхийг баталгаатай эдлүүлэх, сонгуулийн, сонгогчдын хүсэл зоригийн чөлөөт илэрхийллийг тусгахад чиглэж байна.

Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан чөлөөтэй сонгох зарчим нь сонгогч, нэр дэвшигч, нам, эвслийг дэмжих, эсвэл дэмжихгүй байх сонголтоо албадлага, дарамт, сүрдүүлэг, эсхүл гаднын зүй бус нөлөөлөлгүйгээр өөрийн итгэл үнэмшил үзэл бодлын дагуу хийж саналын хуудас тэмдэглэх агуулгатай. Иймээс сонгогч нэр дэвшигч нараас сонгохдоо тухайн тойрогт ноогдсон мандатын тооноос илүү санал тэмдэглэж болохгүй ч хэнийг ч дэмжсэн санал өгөөгүй байх.

Мөн өөрийн дэмжсэн нэр дэвшигчийн тоо тухайн тойрогт ноогдсон мандатын тооноос цөөн байвал уг мандатын тооноос дутуу хэмжээгээр зөвхөн өөрийн дэмжсэн нэр дэвшигчийн төлөө саналаа тэмдэглэх эрхтэй байна.

4.2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт хэсэгт тойрогт ногдсон мандатын тооноос дутуу нэр дэвшигчийн төлөө саналаа тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцохоор хуульчилснаар сонгогч өөрийн сонголтоо хүчингүйд тооцуулахгүйн тулд дэмжээгүй нэр дэвшигчийн төлөө санал нэмж тэмдэглэхээс өөр аргагүйд хүрэх нөхцөлийг бүрдүүлжээ. Тус зохицуулалт нь эрх зүйн тодорхой байдлын болон тохирсон байх зарчмыг хангахгүй байх тул чөлөөтэй сонгох зарчмыг зөрчсөн байна аа.

Нэг ч нэр дэвшигчийн төлөө санал өгөөгүй саналын хуудсыг хүчинтэйд тооцох атлаа тойрогт ноогдсон мандатын тооноос дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцохоор хуульчилсан нь хоорондоо зарчмын хувьд зөрчилтэй, сонгогчийг төөрөгдөлд оруулж болохоор байх тул эрх зүйн тодорхой байдал алдагдсан байна аа.

Маргаан бүхий заалт нь сонгогч саналаа тэмдэглэхэд дэмжлэг үзүүлж сонгох эрхийг бүрэн утгаар эдлүүлэх зорилготой мэт боловч сонгогч тухайн тойрогт ноогдох мандатын тооноос дутуу нэр дэвшигчийн төлөө санал өгөх сонголтыг үгүйсгэж сонголтоо илэрхийлсэн саналыг нь үл тоолох улмаар чөлөөтэй сонгох зарчмыг хамгийн бага хязгаарласан байх арга зам гэж үзэхээргүй байх тул зайлшгүй тэнцвэртэй байх шалгуурт нийцээгүй байна аа.

Сонгогч өөрийн дэмжээгүй нэр дэвшигчийн төлөө саналаа тэмдэглэхийг хуулиар албадаж байгаа нь тодорхой нэр дэвшигчийг дэмжихгүй гэсэн сонгогчийн итгэл үнэмшил үзэл бодлыг үл хүндэтгэсэн байх тул Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь заалтын итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг хөнджээ.

4.3.Тойрогт ногдсон мандатын тооноос дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн бол саналын хуудсыг хүчингүйд тооцохоор хуульчилсан нь аль ч нэр дэвшигчийн төлөө саналаа чөлөөтэй өгөх эрхийг үндэслэлгүйгээр хязгаарлаж сонгогчдын хүсэл зоригийн чөлөөт илэрхийллийг гажуудуулах үр дагавартай байна аа. Түүнчлэн сонгогч өөрийн дэмжсэн нэр дэвшигчийн төлөө өгсөн саналаа хүчинтэйд тооцуулахын тулд хуулийн албадлага дор дэмжээгүй нэр дэвшигчийн төлөө нэмж санал өгөхөөс өөр аргагүйд хүрч байгаа нь өөрийн санал буюу үзэл бодлыг эс баримтлахад тулгаж байх тул үзэл бодолтой байх туйлын эрхийг хөндсөн байна аа.

Иймээс маргаан бүхий зохицуулалт нь иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 19 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт заасан үзэл бодолтой байх эрх болон 25 дугаар зүйлийн Б хэсэгт заасан сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг үндэслэлгүйгээр хязгаарлаж Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ зарчмыг баримталж 2 дахь хэсэгт Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ гэж заасантай харшилж байна.

4.4.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт Үндсэн хуулийн цэцийн шийдвэр буцаж үйлчлэх хүрээг тодорхойлсон

учир энэхүү дүгнэлт нь гарсан цагаасаа хойш үйлчлэх бөгөөд буцаж үйлчлэхгүй үр дагавартай болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт тойрогт ноогдсон мандатын тооноос дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно гэж заасны дутуу гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд чөлөөтэй сонгох эрхийн үндсэн дээр сонгоно гэснийг зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн дутуу гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

Даргалагч Г.Баясгалан, гишүүд Ж.Эрдэнэбулган, Д.Гангабаатар, О.Мөнхсайхан, Б.Болдбаатар.

Анхаарлаа хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Цэцийн дүгнэлтийн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг танилцуулна аа. Индэрт урьж байна.

Г.Уянгахишиг: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай 4 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлт.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1. 1 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай 4 дүгээр дүгнэлтийг 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасан журмын дагуу 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаарх товч танилцуулгыг танилцуулсан болно.

ХЗБХ-ны хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг сонгуулийн хуудсыг дутуу бөглөсөнтэй холбогдуулан саналын хуудсыг хүчингүйд тооцсон талаарх статистик тоо баримтын талаар болон сонгогчдын зонхилох хандлага, мэдрэмж ямар байгаа талаар судалсан эсэх, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 4 дүгээр дүгнэлтийг тайлбартайгаа үндэслэснийг Үндсэн хуулийн цэц харгалзаж үзсэн эсэх талаар, Цэцийн дүгнэлтийг хүлээн авах тохиолдолд бүсчилсэн хөгжлийн хүрээнд ямар үр дагавар гарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан Үндсэн хуулийн цэцийн 4 дүгээр дүгнэлтийг дэмжиж байгаа талаар байр сууриа илэрхийлж итгэмжлэгдсэн төлөөлөгчийн байр сууриас уг асуудал нь Үндсэн хууль зөрчөөгүй гэдэг талаас гаргасан тайлбарын үндэслэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Үндсэн хуулийн цэцийн шийдвэр нь сонгуулийн тогтолцоонд хэрхэн нөлөөлөх мөн улс төрийн намуудын төлөвшилд ямар сөрөг үр дагавар авчрах, өмнөх парламентын сонгуулиудын туршлагаас ямар алдаа, оноо, сургамжийг үндэслэж авч хэлсэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Үндсэн хуулийн цэцийн 4 дүгээр дүгнэлтийг хүлээн авсан тохиолдолд нийгэм болон улс төрийн хүрээнд гарах сөрөг үр дагавар итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд энэ дүгнэлтийн нөлөөллийг хэрхэн үнэлж байгаа талаар тус тус асуулт асууж хариулт авсан болно оо.

Байнгын хорооны хуралдааны үеэр уг асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг дэмжиж буйгаа илэрхийлж тус шийдвэр нь иргэний сонгох эрхийг хамгаалж улс төрийн тогтолцоог сайжруулахад чухал нөлөөтэй сонгуулийн тогтолцоог зөв байгуулах, мөнгөний нөлөөллийг бууруулах, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг санал өгөх эрх болон сонгох эрхийг нэр томъёоны хувьд зарим улс оронд хэрхэн ойлгож хэрэгжүүлдэг талаар, олон санал өгөх эрхүүд нийлж сонгох эрх болдог буюу энэ коллективын эрхийг эдлэхийн тулд сонгуульд хариуцлагатай идэвхтэй оролцдог онолын талаар, цэцийн шийдвэрийг хүлээн авах тохиолдолд улс төрийн намын төлөвшил иргэдийн сонгох эрхийг эдлэх боломжийг анхаарах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан Үндсэн хууль хүний эрхийг хамгаалах сонгуулийн хууль зөрчигдөхгүй байх нөхцөлийг хангах ёстой тул цэцийн дүгнэлтийг дэмжих нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр сонгуулийн тогтолцоонд нөлөөлөх шийдвэрийг парламентын гишүүд нухацтай авч үзэх шаардлагатай бөгөөд Байнгын хороо шийдвэр гаргахдаа үндэслэлээ тодорхой боловсруулж Улсын Их Хурлын чуулганд оруулах ёстой талаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авах нь улс төрийн сөрөг үр дагавар үүсгэж болзошгүй бөгөөд иргэдийн сонгуулийн оролцоо санал өгөх боломжийг нэмэгдүүлэх талаар тус тус үг хэллээ.

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт тойрогт ноогдсон мандатын тооноос илүү, эсвэл дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн нам эвслийн санал тэмдэглэх хэсэгт 1-ээс илүү нам, эвсэл санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно гэж заасны “дутуу” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Их Хурлын гишүүнийг

Монгол Улсын сонгуулийн эрх бүхий этгээд этгээд иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж 4 жилийн хугацаагаар сонгоно гэснийг зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 4 дүгээр дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 4 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Цэцийн дүгнэлтийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа танилцуулна аа. Индэрт урьж байна.

Э.Болормаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 4 дүгээр дүгнэлтийг 2025 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороо, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасан журмын дагуу 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн итгэмжлэгдсэн төлөөлөгч Г.Уянгахишиг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар товч танилцуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг хэлэлцсэн үеийн хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, тухайн зохицуулалтын талаар ойлголтоо бүрэн авч шийдвэр гаргах нь зүйтэй талаар, одоогийн хуулийн зохицуулалтаар сонгогч хөндлөнгийн нөлөөгүйгээр сонгох эрх олгогдсон бөгөөд ард түмний төлөөллийн байгууллага бүрэн байх зарчмыг хангахад сонгогч үүргээ хэрэгжүүлж байгаа учраас чөлөөтэй сонголт хийх эрхийг хязгаарласан гэсэн энэхүү дүгнэлтийг хэлэлцүүлгийн үед анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авснаар чөлөөт сонголт хийх гэдгийн ард зарим нэгэн тойргийн төлөөлөл хаягдах магадлалтай. Хүн амын жигд бус төвлөрлөөс шалтгаалж аймаг, орон нутгийн сонгогчдыг төлөөлөх төлөөллийн харьцаа алдагдах талаар тус тус үг хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт тойрогт ноогдсон мандатын тооноос дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно гэж заасны “дутуу” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд чөлөөтэй сонгох эрхийн үндсэн дээр сонгоно гэснийг зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025

оны 4 дүгээр дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 4 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье өө.

16 гишүүнээр тасаллаа.

Ирсэн дарааллын дагуу Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууж үг хэлье.

А.Ариунзаяа: Төрийн байгуулалтын болон ХЗБХ-ны дэмжээгүй саналыг дэмжиж байна аа. Аливаа улс орон сонгуулийн тогтолцоо нь өөр байдаг. Яагаад гэхээр тухайн улс орны өөрийнх нь хөгжлийн нөхцөл байдал тухайн тулгамдаж байгаа асуудал дээр нь суурилж тухайн сонгуулийн тогтолцоо нь байдаг манай улсын хувьд хэт жижиг мажоритар энэ тогтолцоо маань өөрөө хэт нутгархах хэт мөнгөний энэ фактор орж ирэх, хэт популист улс төрийг дэмжих ийм нөхцөл байдал байгаа учраас аль болох төлөөллийн болон тэгш байдлыг оруулсан шинэ тогтолцоог бол бид нар нэвтрүүлсэн.

126 гишүүний 78 нь тойргоос сонгогдож байгаа, 48 нь жагсаалтаар сонгогдож байгаа. Тойргоос сонгогдсон 78 хүний 8 хүн нь л эмэгтэй гишүүн байна аа. Тэгэхээр тойргоос эмэгтэйчүүдэд сонгогдоход маш хүнд байна гэдэг нь бол энэхүү тооноос харагдаж байгаа юм. Бүсчилсэн тойргуудаар томсгосон тойргийн энэ мажоритар тогтолцооны гол онцлог нь жишээлбэл баруун бүсийн 10 мандаттай байлаа гэхэд арвууланг нь дугуйлж байж сая танигдалт нь бага ч гэсэн шинэ залуу болон эмэгтэйчүүд бусад шинэ улс төрчдийг оруулж ирэх мөн түүнчлэн бага төлөөлөлтэй цөөн сонгогчидтой аймгийн төлөөллийг тэгш оролцуулах энэ тогтолцоо байгаа юм аа. Ийм учраас үүнийг хэрэвзээ эвдэх юм бол маш олон сонгогчидтой, мөн түүнчлэн олон нийтэд танигдсан мөнгөний фактаар хэт их орсон ийм улс төрчид л Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдоно оо.

Ийм учраас үүнийг бол байгаагаар нь явуулах учиртай. Дэмжээгүй саналыг бол дэмжиж байна. Эмэгтэйчүүдийн энэ сонгогдох эрхтэй холбоотой бид жагсаалтын 48-ын 50 хувь нь бол эмэгтэйчүүд байгаа.

24 эмэгтэй жагсаалтаар орж ирсэн, 8 эмэгтэй бол тойргоос орж ирсэн. Улс төрийн намууд нийт нэр дэвшүүлж байгаа 126 мандатын 30 хувьд нь бол эмэгтэйчүүдийг дэвшүүлсэн. 2028 онд 40 хувийг дэвшүүлэх үүргийг Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн тухай хуулиар хүлээж байгаа. Ингэхээр тойрогт сая намууд 14 эмэгтэйг дэвшүүлсэн. Нам тус бүр 14 эмэгтэйг дэвшүүлсэн. Нийтдээ Улс төрийн намуудаас наймхан эмэгтэй тойргоос сонгогдож орж ирсэн. 28 онд тойрогт энэ эдгээр 14 дээрээ нэмээд 12 эмэгтэйг дэвшүүлнэ ээ улс төрийн намууд.

24 жагсаалтаар 26 эмэгтэйг улс төрийн намууд тойргоос дэвшүүлэх үүргийг хүлээж байгаа. Ийм учраас одоо энэ эмэгтэйчүүдтэй холбоотойгоор хүний эрхийн комиссын энэ 24 дэх илтгэл дээр хүртэл гарсан. Эмэгтэй улс төрчдийг сонгуулийн үйл ажиллагааны энэ үеэр олон нийтийн сүлжээний платформ ашиглаж фэйсбүүкийн 11 хувь, твиттерийн 13 хувь эмэгтэй нэр дэвшигчид рүү халдсан, зүй бусаар доромжилсон, боловсрол хүйсээр нь дорд үзсэн, худал мэдээлэл тараах, гүтгэх, ижил нэрээр хуурамч хаяг нээх гэх зэрэг ийм ялгаварлан гадуурхалтыг бий болгодог. Эмэгтэйчүүдийг улс төрийн ажилд тохирохгүй гэж бусдад итгүүлэх, авч хэрэгжүүлсэн үйл хэрэг бодлого зэргийг зэргийг ярихгүйгээр гадаад төрх байдлаар нь доромжлох, эмэгтэйчүүдийн үнэт зүйлийг шүүмжлэх зэргээр тэдэн рүү дайрсан дайралтууд түгээмэл байдаг гэж үндсэн энэ Хүний эрхийн Комиссын 24 дэх илтгэл дээр нь оруулсан байгаа юм.

Тэгэхээр гарааны ийм тэгш бус байдалтай байхад яаж эмэгтэйчүүдээ харин ч дэмжих вэ гэдэг тал дээр сонгуулийн тогтолцоо маань улам эерэг болох ёстой. Ийм учраас хэрэвзээ тухайн байгаа мандатын тоогоор дугуйлахгүй байна гэж үзэх юм бол эмэгтэйчүүдэд улам их эрсдэлтэй болох учраас Цэцийн энэ шийдвэрийг дэмжихгүй байгаагаа илэрхийлье ээ.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Дуламын Бум-Очир гишүүн асуулт асууж, үг хэлье.

Д.Бум-Очир: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Цэцийн дүгнэлт зөв гарсан байна гэдэг бодолтой байна.

Хоёрт Цэцийн дүгнэлтийг Их Хурал хүлээж авах нь зүйтэй юм болов уу гэсэн ийм бодолтой байгаа ийм байр суурьтай байгаа. Энийгээ би 4 үндэслэлээр тайлбарлая аа.

Нэгдүгээрт, Цэц дээр маш төстэй ийм гомдлууд өмнө нь ирж байсан. Тэгээд дүгнэлт нь голдуу энэ Үндсэн хуулийн болоод сонгох эрхийг зөрчиж байна гэсэн ийм дүгнэлтүүд удаа дараа гарч байсан юм байна аа. Тэгээд мандатын тоонд хүрэхгүй санал өгсөн хуудсыг хүчингүйд тооцох нь иргэний эс сонгох эрх буюу одоогийн тохиолдолд бол энэ бид нар цагаан сонголт гэж яриад байдаг. Заримдаа энэ цагаан сонголт хийчихсэн байгаа эрхийг нь хязгаарлаж байгаа гэсэн ийм зүйл харагдаж байгаа юм. Өөрөөр хэл иргэн хэсэгчлээд цагаан сонголт хийчихсэн байгаа юм аа.

Тухайлбал одоо 9 мандатын 5-ыг нь сонгочихсон, 4-ийг нь сонгоогүй гэвэл дутуу сонгосон гэдэг үндэслэлээр хүчингүй болгочих юм бол тэр 5 сонголтыг нь хүчингүй болгох замаар сонгогчийн саналыг хүчингүйд тооцож байгаа ийм зүйл харагдаж байгаа юм.

Дараагийн үндэслэл бол юу вэ гэхээр түрүүн бас цэцийн дүгнэлтэд гарсан. Одоогийн хүчин төгөлдөр хуулиар бол огт санал тэмдэглээгүй хуудсыг хүчингүйд тооцохгүй, хүчинтэйд тооцож байгаа. Гэтэл огт санал тэмдэглээгүй хуудсыг хүчинтэйд тооцож байгаа мөртөө дутуу тэмдэглэснийг хүчингүйд тооцож байгаа нь хуулийн зөрчил үүсгэж байгаа гэдгийг түрүүн цэцийн дүгнэлт дээр харсан.

Түүнээс гадна би бас нэгэн мэдээллийг гишүүддээ хүргэмээр байна. Энэ юу вэ гэхээр 1996 онд гарсан маш төстэй явдал байгаа юм аа. Энд юу болсон бэ гэхээр 1996 оны хуулийн Сонгуулийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр санал огт

тэмдэглээгүй саналын хуудсыг хүчингүйд тооцох тухай заалт орж ирсэн. Үүнийг Ховд аймгийн харьяат Чулуунжав гэдэг хүн Цэцэд гомдол гаргаад 1996 оны 5 дугаар сарын 23-ны 3 дугаар дүгнэлтээр энэхүү цэцийн 3 дугаар дүгнэлтээр энэ дүгнэлт нь байж байна. Хүлээж авсан байдаг юм байна аа.

Цэцийн энэ дүгнэлтийг яг одоо бид хэлэлцэж байгаа шиг Их Хурал хүлээж аваагүй юм байна. Гэтэл эргээд энэ Их Хурлын чуулганы хүлээж аваагүй дүгнэлтийг Цэц 1996 оны 6 дугаар сарын 19-ний 2 дугаар тогтоолоороо хүчингүй болгочихсон юм байна. Тэгэхээр энэ тогтоол нь энд миний гарт байж байна. Тэгэхээр өнөөдөр юу болох гээд байна вэ гэхээр 1996 онд болсон энэ үйл явдал давтагдах вий гэж бодож байна. Түрүүн бас Сандаг-Очир гишүүний тэр санал байсан. Их Хурал хүлээж авахгүй нь магадгүй эвгүй биш үү? Олон нийтэд дургүйцлийг хүргэх биш үү гэсэн иймэрхүү юм хэлж байсан. Би адилхан санал бодолтой байгаад байна. Цэц Их Хурал хүлээж аваагүй тохиолдолд энэ 1996 оны 6 дугаар сарын 19-ний 2 дугаар тогтоол дээр цэц ямар дүгнэлт гаргасан бэ гэхээр нэгд тэр санал огт тэмдэглээгүй саналын хуудсыг хүчингүйд тооцох тухай хуулийн заалтыг хүчингүй болгосон.

Хоёрт, Их Хурлын гаргасан тэр тогтоолыг бас давхар хүчингүй болгоод тэгээд энэ тогтоолоор энэ шийдвэрийг эцсийн шийдвэр гэж цохон тэмдэглэсэн байгаа юм. Энэ бидэнд нэлээд их сургамжтай үйл явдал болов уу гэж бодож байна. Хэрвээ магадгүй Их Хурал одоо энэ цэцийн дүгнэлтийг хүлээж авахгүй бол 1996 онд болсон энэ үйл явдал шиг Цэц их суудлын хурлаараа энэ хуулийн заалтыг болоод мөн манай чуулганы Их Хурлын тогтоолыг хүчингүй болгох ийм үйл явдал болох вий гэдгийг одоо бас гишүүддээ болоод олон нийтэд хэлмээр байгаа юм аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Амгаланбаатарын Ганбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Алга байна. Байна уучлаарай. Гомбын Ганбаатар гишүүн рүү харчхаж. Амгаланбаатарын Ганбаатар гишүүн асуулт асууж, үг хэлье.

А.Ганбаатар: Байна уу? Цэцийн дүгнэлтийг бол дэмжиж байгаа. Яагаад гэвэл Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн манаач. Ер нь тэгээд Үндсэн хуулийн цэцээс орж ирж байгаа зарим асуудал дээр Их Хурал авахгүй байгаа харагдаад байгаа л даа. Энэ нь олон нийтэд энэ хуулийн зөрчил харагдаж байгаа, гарч байгаа юм шигээр харагдаад байгаа юм. Тэгэхээр Үндсэн хуулийн цэцийг бид нар энгийн үгэндээ бол түүнээс дээш тэнгэр л байгаа гэж ярьдаг шүү дээ. Тэгэхээр Цэцийнхээ дүгнэлтэд үндэслэлтэй суурьтай хандаж баймаар байгаа юм. Тэгээд саяын үндэслэлүүд бол үнэхээр энэ хүний сонгох, сонгогдох эрхэд нь тулгуурласан зөв шийдвэр гаргасан байна шүү дээ, дүгнэлт.

Тэгээд яагаад Хууль зүйн байнгын хороо энийг авахгүй гэж орж ирж байгаа юм бол? ХЗБХ-ны дарга гишүүдээс асуумаар байна л даа. Цагаан хуудас цагаан сонголт гэж бид нар өгдөг шүү дээ аль ч хүнийг нь дэмжихгүй байна тэгээд яагаад энийг дэмжихгүй байгаа юм. Хүнийг хэнийг ч сонгох вэ байх эрхийг нь хаагаад байна шүү дээ. Эс сонгох эрхийг нь боомилж байна шүү дээ. Тэгээд дээр нь гуя дагаж хүзүү орж ирдгийг энэ чинь хааж байгаа.

Хоёр том нам бол юу гэдэг юм 9 хүнтэй тойрогт бол жишээлэхэд багаар нь дэмжээрэй гээд багцлаад өгдөг. 10 хүнтэй тойрогт багаар нь дэмжээрэй гээд багцлаад явдаг. Ард нь мөнгө санхүүгийн асуудал яригддаг. Энэ чинь сонгуулийг шударга бус болгож байна. Жижиг нам буюу бие даагч нарт орон зайг нь хааж байна гэж ярьдаг шүү дээ. Тэгээд Хууль зүйн байнгын хороо нь өөрөө энэ Үндсэн

хуулийнхаа дүгнэлтийг хаасан ийм шийдвэр Их Хурал руу оруулж ирээд байх юм. Тэгээд Их Хурлын гишүүдийг эвгүй байдалд оруулаад цэцтэй маргалдах ийм сэжүүр гаргаад байх юм аа.

Тэгэхээр миний хувьд бол Их Хурлын гишүүдээс уриалах нь бол гишүүд нэг зоригтой байж байгаад тэр намын бодлогоосоо нэг удаа ухраад энэ сонгох сонгогдох эрхийг нь хүндэл л дээ энэ иргэдийнхээ. Тэгээд энэ гишүүд чинь та нарыг сонгох сонгохгүй нь та нарын чинь үйл ажиллагаанаас л хамаарч сонгоно шүү дээ. Энэ 4 жилд юу хийсэн юм, яасан ийсэн гээд. Тэрэнтэй нэг үнэнтэй нүүр тулаад хэн нь хэнийг сонгох вэ, хэн нь хэнийг сонгохгүй байх гэдгийг энэ сонгогчид нь үлдээвэл яасан юм бэ гэж байгаа юм.

Тэгээд хамгийн гол юм бол энэ ХЗБХ яагаад энийг ийм шийдвэр гаргаж байгаа юм, ийм дүгнэлт гаргаж байгаа юм бэ гэдгийг асуух гэсэн юм л даа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Энхбатын Болормаа гишүүн асуултад хариулъя.

ТББХ-ны дарга ОХУ-д Ерөнхийлөгчийн айлчлалын бүрэлдэхүүнд гадагшаагаа явсан байгаа. Сархадын Зулпхар гишүүн асуулт асууж, үг хэлье.

С.Зулпхар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье ээ.

Бид их чухал зүйл хэлэлцэж байна. Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуульд холбогдох хуулиуд Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргадаг ийм эрх бүхий субъект, ийм эрх бүхий байгууллага. Гэхдээ энэ дээр бол гаргасан дүгнэлтийг хүлээж авах эсэх асуудал нь бол Улсын Их Хурлын өөрийнх нь бүрэн эрх. Энэ дээр саналаа илэрхийлэх нь гишүүдийн бүрэн эрх ээ. Нэн тэргүүнд би нэг ийм зүйл хэлмээр байна. Яг энэ асуудалтай холбоотой шийдвэр дүгнэлт бол 1993 онд гарчихсан. Тухайн үед Үндсэн хуулийн цэцээс яасан гэхээр зэрэг энэ ижил төстэй ийм заалт байж байгаа юм л даа. Тэр нь бол тухайн үеийн Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 36.3-д санал огт тэмдэглээгүй эс үгүй бол мандатын тооноос дутуу буюу илүү тэмдэглэсэн энэ хуульд зааснаас өөр ямар нэг тэмдэглэл хийсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно гэдэг нь бол Үндсэн хууль зөрчөөгүй гэдэг ийм дүгнэлт гаргачихсан байхгүй юу. Энэ дүгнэлт аль 32 жилийн өмнө гарчихсан. Энэнээс хойших хугацаанд эрхэм гишүүдээ нэг зүйлийг бид ойлгох ёстой. Монгол Улсад ардчилсан жишээ нь дэглэм хэвээрээ байж байгаа. Үндсэн хуулиар бид нар төрийн байгуулалт бол парламентын засаглалтай хэвээр байж байгаа. Төрийн байгууламжийн хувьд бол бид нар нэгдмэл улс хэвээрээ байж байгаа. Үндсэн хуулийн үндсэн зарчим бол хэвээрээ байж байгаа. Гэтэл өнөөдөр одоо жишээ нь 2024 оны дүгнэлт нь бол Үндсэн хууль зөрчсөн гэдэг ийм дүгнэлт гарч байгаа нь өөрөө бол бас эргэлзээ төрүүлж байна гэж байгаа юм. Энэ асуудлыг бол судалж үзсэн.

ТББХ-н дээр ч гэсэн бид энийг бол их тодорхой ярьсан. Чөлөөтэй сонгох эрх гэдэг нь юу юм бэ гэж. Энэ бол цэвэр онолын маргаан. Энэ цэвэр практик маргаан байгаа юм. Чөлөөтэй сонголт гэдэг бол 2 болон түүнээс илүү хувилбараар сонголт хийх боломжийг олгосон байхыг чөлөөтэй сонголтоо гэж хэлж байгаа юм. Тэгэхээр яг энэ жишээ нь шалгуураар нь аваад үзэх юм бол чөлөөтэй сонгох эрх нь байж байгаа юм. Сонгогчдын хувьд бол. Тэгэхээр энэ бол ямар нэгэн байдлаар энэ

сонголтын зарчмыг бол зөрчөөгүй гэж үзэж байгаа учраас энийг та бүхэн харуулаач гэж байгаа юм.

Цаашлаад чөлөөтэй сонголт гэдэг бол ямар нэгэн жишээ нь этгээдийн шахалт дарамтад жишээ нь санал өгөхгүй байх. Энэ нөхцөлийг хэлж байгаа юм. Тэгэхээр энэ зарчим зөрчигдөөгүй гэж байгаа юм. Шууд бус, шууд сонгох эрхт нь халдаж байна гэж байгаа юм. Шууд сонголт гэдэг бол ямар нэгэн одоо жишээ нь институцээр дамжуулж сонгуулийн ямар нэгэн төлөөллийн байгууллагаар дамжуулж саналаа өгөхийг хэлдэг. Ингээгүй учраас энийг зөрчөөгүй гэж үзэж байгаа юм аа.

Цаашлаад сонгууль бол сонголт хийх нь бол бас нэг талаар эрх боловч, нөгөө талаар үүрэг. Бид бол төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс учраас энд сонголтыг бүрэн хэрэглэх үүрэг өөрөө дагалддаг. Сонголттой холбоотой үүргүүд их олон байдаг л даа. Тэгэхээр энэ үүднээс нь аваад үзэх юм бол сонголтыг төлөөллийн байгууллагад бүрэн болгох үүднээс энэ зохицуулалт хийгдсэн. Энэ бол Монгол Улсын Үндсэн хуулийг 1992 онд батлах энэтэй уялдсан байдлаар Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг жишээ нь гарах үед бол маш тодорхой судлагдаад тэр олон улсын нийтлэг зарчим ардчилсан дэглэмтэй улсуудын тэр зарчмыг бүрэн тусгасан ийм сонголтын хэлбэр байгаа учраас сонголтын зарчим байгаа учраас Үндсэн хуулийн цэцийн энэ шийдвэрийг бид хүлээж авах боломжгүй байна гэдэг дүгнэлтийг ТББХ-н дээр ярьж байж гаргасан гэдгийг та бүхэнд хэлье ээ. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууж, үг хэлье.

О.Номинчимэг: Ер нь яах вэ асуулт асууя гэхээр нөгөө эрхэлсэн Байнгын хорооны дарга нар байхгүй яг энийг боловсруулсан нь хаанаас орж ирж байгаа, хэн ажилласан гэдэг нь бас их тодорхойгүй байгаа. Тэгээд миний хувьд бол яг энийг авч хэлэлцсэн 2 Байнгын хорооны гишүүн байр сууриа илэрхийлж энэ цэцийн дүгнэлтийг хүлээж авах ёстой гэж үзэж байгаа. Тэрний гол учир шалтгаан бол бид энэ сая гишүүд ч гэсэн дурдаж байна л даа. Цагаан хуудас гэдэг юмыг сонголтын бас нэг хэлбэр гэж хүлээн зөвшөөрч байгаа атал яг энэ нэр дэвшигч дээр болохоор өөрийнхөө таалагдаагүй эсвэл яах вэ дээ энэ гарсан ч яах вэ, гарахгүй байсан ч яах вэ гэсэн ийм нэг сонголтыг заавал хийхгүй бол өөрийнх нь бусад хийж байгаа сонголт нь хүчин төгөлдөр тооцогдохгүй энэ байгаа явдал бол бас л энэ Цэцийн дүгнэлтэд дурдсан тэр хүчээр бараг эрх чөлөөнд нь халдаж сонголтыг хийлгэх энэ механизм нь болоод байна гэдэгтэй бол би санал нэгдэж байгаа.

Тэгээд энийг ярихаар яах вэ энэ үндэслэлийг харах юм бол өмнөх энэ Цэцийн шийдвэр чинь ийм байна шүү дээ гэдэг юм байна. Энэ бол яах вэ тэр техникийн хүрээнд бол Цэц өөрөө яаж энийг шийдвэрлэсэн юм? Яагаад адил биш гэж үзсэн юм гэдгээ илүү нарийвчлаад тайлбарлавал гараад л ирэх л байх. Энэ бүсчилсэн хөгжилтэй холбоотой эсвэл нутаг жалганы үзэл ч гэдэг юм уу ингээд үзэхээр энэ өөрөө суурь асуудал нь биш. Бид нар уг нь бол яг одоо нөгөө сонгууль дээр болохоор нөгөө сонгогчдын боловсролын асуудал. Дээр нь нам өөрөө ямар институц болох ёстой юм бэ гэдэг асуудал байдаг. Тэгээд бид нар улс төрийн намын тухай хуулиа шинэчлээд, нам өөрөө бодлогын институц байх ёстой. Намыг дэмжигчид гишүүд гэдэг нь яг энэ бодлогыг нь үнэхээр дэмждэг байр сууриа илэрхийлдэг ийм болж төлөвшихгүй бол одоогийн манай Монголд байгаа улс

төрийн намуудын үйл ажиллагаа, гишүүнчлэл, энэ дээрээ үндэслээд сонгуульд орж байгаа үл үзэгдэл бол гажуудалтай байгаа.

Тэгэхээр энэ цэцийн дүгнэлтийг хүлээж аваад хүлээж авснаар юу үр дүнд хүрэхээр байна. Яах вэ ингээд л намын институт нь яана ийнэ гэдэг янз бүрийн асуудлууд гишүүд ярьж байгаа бид нар илүү энэ гажуудлын засахын төлөө дахиад нөгөө улс төрийн намаа тэгвэл илүү бодлогын болгоё улс төрийн намын нөгөө нэг хуулиа хэрэгжүүлбэ. Намын гишүүнчлэлээ илүү энэ бодлогын чанартай юм руу чиглүүлбэ. Дээр нь сонгогчдын боловсрол гэдэг юман дээрээ нийтээрээ анхаардаг болъё. Ингэж байж сонгогч өөрөө боловсролтой болж байж ямар сонголт хийх вэ гэдэг юм нь илүү ойлгомжтой болно. Эрх чөлөөтэй сонголтоо хийж чадна гэдэг юм руу орно гэж үзэж байгаа.

Тэгэхээр асуулт асууна гэхээсээ илүү хувь гишүүний хувьд бол энэ цэцийн дүгнэлтийг хүлээж авах нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа гэдгээ хэлбэ ээ.

Д.Амарбаясгалан: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууж, үг хэлбэ.

Д.Энхтүвшин: Би цэцийн дүгнэлтийг хүлээж авах ёстой гэж бодож байгаа. Яагаад вэ гэхээр ер нь Үндсэн хууль бол бид нар сая өнгөрсөн оны 11 сард Үндсэн хуулиа дээдлэх ийм Улсын Их Хурлын тогтоол баталсан. Тэгээд энэ утгаараа ч гэсэн энэ Үндсэн хууль дээр бол улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөөг хамгаалж баталсан суурь хууль байдаг. Тэгэхээр хүний эрх эрх чөлөөн дотор сонгох эрх бол маш том үүрэг роль гүйцэтгэж чаддаг.

Тэгэхэд 71.10 дээр нь Улсын Их Хурлын тухай хуулийн 71.10 дээр нь хэнийг ч сонгохгүй байгаа эрхийг нь хүлээн зөвшөөрсөн мөртөө өөрийнхөө сонгох хүмүүсийг сонгоод сонгомооргүй хүмүүсийн сонгохгүй эрхийг нь хязгаарлаж хүчээр хэн нэгэнд санал өгүүлнэ гэдэг нь яг энэ хүний үндсэн суурь эрхийг зөрчиж байгаа ийм асуудал байгаа. Тэгэхээр энийг эсэргүүцэж байгаа гэх юм уу даа. Хүлээж авахгүй гэж ярьж байгаа үндэслэлүүдийг нь харахад бол ер нь улс төрийн намтай холбоотой нэр дэвшигчид хоорондын зөрчилтэй холбоотой, улс төрийн намуудын төлөвшилтэй холбоотой, тойргийн хуваалттай холбоотой, сонгуулийн тогтолцоо системтэй холбоотой. Өөрөөр хэлбэл энэ 2 дугаар асуудал байх.

Дараагийн асуудлууд хүний эрх энэ сонгож, сонгогдох сонгох эрх бол үндсэн суурь эрх учраас энэ эрхийг нь хангаж өгөх хэрэгтэй гэж бодож байгаа юм. Жишээлбэл одоо жишээ авъя л даа. Энэ сонгуулийн тогтолцоо маань илүү эрх барьж байгаа юм уу олонд танигдсан намуудад л илүү давуу талуудыг олгож байна. Жишээ авахад энэ 2 дугаар тойрог дээр 10 мандаттай байсан байна. Тэгээд эндээс МАН, АН, Үнэн ба зөв нам, Иргэний хөдөлгөөн намаас 10 хүн нэр дэвшүүлээд бусад намаас 1-ээс 4 хүн нэр дэвшүүлсэн байна л даа.

Тэгэхээр ингээд яг тэр дунд өөрийнхөө сонгох хүнээ дэмжиж сонгогчхоод, үлдсэнийг нь хүчээр энэ саяын нэр дэвшсэн намуудаас сонгохоос өөр аргагүй ийм болчихож байгаа юм. Тэгэхээр энэ бол бусад тойргууд дээр ч гэсэн яг адилхан иймэрхүү дүр зураг харагдаж байгаа юм. Тэгэхээр энийг Үндсэн хууль Улсын Их хурал дээр бид нар хүн төвтэй хууль эрх зүйн орчин бий болгохоор зорьж стратеги төлөвлөгөөгөө гаргасан байгаа. Тэгээд Үндсэн хуулийн зарчим ч байна. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүдийг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн авч энэ сонгогчдын хүний эрх сонгох эрхийг хангахыг хүсэж байна аа.

Д.Амарбаясгалан: Энхтүвшин гишүүн үг хэллээ. Энэ гишүүд бас энэ иргэдийн сонгох сонгогдох эрхтэй холбоотой яг энэ сонгуулийн процесстой холбоотой асуудлаар Улсын Их Хурлын сонгууль, Ерөнхийлөгчийн сонгууль гээд энэ сонгуулиудын ялгаа заагийг нэлээн харах нь зүйтэй байх гэж бодож байгаа юм. Ерөнхийлөгчийн сонгууль дээр бол яг гишүүдийн хэлээд байгаагаар сонголтгүй сонголт хийх шаардлага тулгаад байдаг. Харин сүүлийн удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулиуд дээр сонголт байхгүй бол цагаан хуудсаа өгөх эдлэх тэр эрхээ эдлэх боломж бол сонгогчдод нээлттэй болсон. Хоёр ч удаагийн Ерөнхийлөгчийн сонгууль дээр цагаан хуудас өгсөн сонгогчдын тоо бол нэлээдгүйгээр гарч ирсэн нь иргэдийн эрх илүү их хангагдаж байгаа байдал ажиглагдаж байгаа юм.

Улсын Их Хурлын сонгууль талаас харах юм бол ахиад өөр. Нэг тойрог дээр 5 намаас 1, 1 хүн дэвшүүлчхээд энийг заавал сонго гэж шахаж байгаа зүйл биш шүү дээ. Нэг тойрог дээр тухайлбал өнгөрсөн 2024 оны сонгуулийн жишээ авах юм бол баруун бүс дээр 10 мандат дээр 126 хүн нэр дэвшчихсэн. Тэр 126 дотроос иргэд аль ч намын хэнийг ч сонгох эрх нь бол нээлттэй байдаг байхгүй юу. Тэгэхээр энэ ялгаа заагийг бас олон талаас нь хараад энэ олон улсуудад энэ сонгуулийн нэрийн жагсаалт гаргаж байгаа пропорциональ мажоритартай холбоотой жагсаалт гаргаж байгаа дээр нээлттэй хаалттай гэдэг ийм ойлголтууд байж байдаг. Тэгэхээр энэ өөрөө бас онолын суурьтай, сонгуулийн системтэй холбоотой ийм асуудлууд байдгийг нөгөө иргэдийнхээ сонгох сонгогдох эрхтэй холбож шууд тайлбарлах өрөөсгөл байдаг юм шүү гэдгийг гишүүддээ хэлье. Мэдээж одоо цэцийн дүгнэлтийг хүлээж авах байр суурийг Улсын Их Хурал бол өнгөрсөн 3 удаагийн дүгнэлтийг хүлээж авсан. Цэцийн гаргасан шийдвэрт илүү хүндэтгэлтэй хандаж явж байгаа. Гэхдээ мэдээж асуудал болгон шууд 100 хувь Цэцийн зөв байна гэдэг ойлголт бас байж болдоггүй. Энэ өөрөө олон талын нөхцөлд дүгнэлт гаргасны үндсэн дээр шийдвэр гаргадаг учраас Улсын Их Хурлын гишүүд мэдээж энэ гаргасан санал, дүгнэлт үндэслэлтэй холбогдуулж шийдвэр гаргах байх гэж бодож байна аа.

Лхагвын Мөнхбаатар гишүүн асуулт асууж, үг хэлье.

Л.Мөнхбаатар: Их Хурлын дарга, Тамгын газрынханд хандаж нэг зүйл хэлье гэж бодож байна.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн урьж Улсын Их Хуралд танилцуулдаг. Танилцуулчхаад чуулганы нэгдсэн хуралдаанд оролцдог, оролцдог л доо. Олон жил энэ ҮХЦ байгуулагдсанаас хойш оролцоод явдаг, сууж байдаг байсан. Энэ удаа ингээд байхгүй байна. Ер нь удаа дараа ийм байгаад байгаа. Гишүүдийн асуултад хариулахгүй байж болно гаргасан шийдвэрийнхээ төлөө түүнийгээ тайлбарлаж хариулахгүй байх ч эрх нь бий. Тэрийг бол хүндэтгэж байна. Гаргасан шийдвэрийг нь хэлэлцэж байгаа энэ хэлэлцүүлгийн явцад бол нь сууж сонсоод, гишүүдийн хэлж байгаа үндэслэл, аргууд, асуудлуудыг нь бол сонсож байх нь зүйтэй. Энэ өмнө нь олон жил явж ирсэн ийм жишиг шүү. Энийг цаашид Тамгын газар байлцуулах нь зүйтэй гэдгийг хэлье гэж бодож байгаа юм.

Дараагийн зүйл. Энэ Үндсэн хуулийн цэцийн 04 дүгээр дүгнэлтийг хүлээж авахгүй байх нь зүйтэй.

Нэгдүгээрт ТББХ мэргэжлийн байнгын хороо бол ХЗБХ хүлээж авахгүй байх нь зүйтэй гэсэн ийм санал, дүгнэлтийг гаргасан. Үүнийгээ гаргаад зогсохгүй хүлээж авахгүй байх үндэслэлээ Улсын Их Хурлын тогтоол хэлбэрээр боловсруулаад үүнийгээ оруулаад ирсэн байж байгаа. Тэгээд хүлээж авахгүй Улсын Их Хурал энийг хүлээж авахгүй гэвэл тодорхой үндэслэлүүд нь Үндсэн хуулийн цэц дээр очно. Үндсэн хуулийн цэц Их Хурлаар хэлэлцэхдээ Улсын Их Хурлаас гаргасан энэ тодорхой үндэслэлүүдийг хэлэлцэх юм.

Ер нь бол Улсын Их Хурал бол хүлээж авахгүй байж болно. Авахгүй байгаа үндэслэлээ бичих юм бол ҮХЦ үүнийг нь хэлэлцдэг ийм жишиг рүүгээ бид нар цаашдаа явах ёстой. Тодорхой үндэслэл байна. Үүнийг нь хэлэлцээд Их суудлынхаа дүгнэлтээ гаргадаг магадлал гаргадаг байх ёстой гэж бодож байгаа юм. Энд би нэг хэд хэдэн зүйлүүдийг хэлчихье гэж бодож байгаа юм. Ерөөсөө л энэ чөлөөтэй сонгох эрх гэдэг дээр хэрхэн яаж ойлгож байна вэ гэхээр өмнө 1993 он, 2007 онд Үндсэн хуулийн цэц өөрөө энэ асуудлаар дунд суудлынхаа хуралдаанаар хуралдаад Үндсэн хууль зөрчөөгүй байна гэсэн ийм дүгнэлт гаргачихсан асуудал, 2 удаа хуралдаад гаргачихсан асуудал шүү.

Тийм учраас энэ асуудлыг ер нь авч хэлэлцэх ёстой байсан уу, маргаан үүсэх ёстой байсан уу гэдэг асуудал эхлээд яригдана. Ингээд үүнийгээ хэлэлцээд явахдаа чөлөөтэй сонгох гэдэг ойлголт дээрээ магадгүй онолын бөгөөд Үндсэн хуулийн үзэл баримтлалтай холбоотой маргаанууд яригдаж байна.

Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн ойлгож байгаа, зарим гишүүдийн ойлгож байгаа асуудал, манай Их Хурлын гишүүдийн ойлгож байгаа ойлголтын хувьд зөрүүтэй ойлголтууд байх шиг байна. Тийм учраас энийгээ бол ярих ёстой. Энд Үндсэн хуульд нэг ийм зүйл байгаа шүү. Үндсэн хуульд бол Сонгуулийн Улсын Их Хурлын сонгуультай холбоотой журмыг хуулиар тогтоох эрхийг бол олгочихсон байгаа юм.

Тийм учраас энэ хуулиар тогтоосон энэ эрх дотроо энэ эрхийнхээ хүрээнд тодорхой энэ мандат журам энэ бөглөхтэй холбоотой энэ техникийн асуудлуудыг шийдэж өгсөн. Энэ асуудлыг бас харгалзан үзэх нь зүйтэй. Энэ хуулийнхаа хүрээнд явж байгаа гэж үзэж байгаа. Энэ Цэцийн дүгнэлт дээр бол нэг ийм зүйлүүд харагдаад байна л даа. Одоо ингээд чөлөөтэй сонгогдох эрхийг зөрчсөн байна гээд үзсэн энэ зүйл нь би ингэж үзэж байгаа юм. Чөлөөтэй сонгох эрхээ хязгаарлаагүй байна гэж би хараад байгаа юм.

Чөлөөтэй сонгох эрхийн суурь утга гэж гэж ярья л даа. Энэ бол сонгуульд оролцохгүй байх оролцох эрх. Энийг чөлөөтэй шийдэх гэсэн энэ асуудал. Иргэн сонгуульд заавал оролцох үүрэг хариуцлага хүлээхгүй байх гэдэгтэй нэг авч үзэж болно. Саналаа нууцаар өгөх эрхийг баталгаажуулахтай холбоотой буюу сонгогчдод сонголт хийх боломж гэж байгаа. Энэ хувилбарыг нь санал болгоод сонгогч тэдгээрээс өөрийн хүсэл зоригоор хөндлөнгийн оролцоонд нөлөөлөлгүй чөлөөт сонголт хийх боломж гэж ойлгож болно. Ингэж ойлгох юм бол энэ чөлөөтэй сонгох гэдэг ойлголтоор энэ ойлголтоор явах юм бол энийг зөрчөөгүй байна гэж үзэж болно.

Саналын хуудсыг бүрэн тэмдэглэхийг шаардахгүй байх нь сонгогчдын төлөөлөл бүрэн хангагдахгүй байх нь ойлгомжтой гэдгийг та бүхэн маань мэдэж байгаа. Нэг тойрогт. Би нэг минутаа нэмье.

Д.Амарбаясгалан: Нэг минут. Нэг тойрогт нэр дэвшигчдийн авсан саналын тоо хоорондоо зөрөөтэй байх гээд энэ тохиолдлууд тэнд тэгш байдлыг алдагдуулна. Их Хурлын олон гишүүд бас энэ дээр яагаад авахгүй байх үндэслэлээ олонтоо сая хэллээ. Ийм учраас эдгээрийг бид нар харгалзан үзээд энэ өмнө гарсан Цэцийн дүгнэлтүүд дээр тавигдсан зүйлүүд үндэслэлүүд маань мөн адил хэвээрээ байж байна. Энд өмнөх дүгнэлтүүдээр хэлсэн зүйл ийм байгаа шүү дээ. Саналын хуудасны техникийн шаардлага болон хүчингүйд тооцох үндэслэлийг зөвшөөрч Үндсэн хуультай нийцсэн гэсэн ийм үндсэн тийм дүгнэлт байгаад байгаа юм. Тэгэхээр тухайн үеийн хууль зүйн орчин, өнөөгийн үеийн хууль зүйн орчин 2-ын энэ мандатын тоонд нийцүүлэн санал өгөх гээд энэ Үндсэн хуульд нийцсэн энэ асуудал нь яг хэвээрээ л байж байгаа байхгүй юу. Тэгтэл энэ шийдвэрүүд гарчихсан. Энэ НҮБ-ын олон улсын нөгөө фактыг үнэлсэн юм байна лээ. Энд бол яг нарийвчилсан зохицуулалтууд байхгүй шүү байхгүй. Ийм учраас эдгээрийгээ үндэслэлүүдээ бичээд ер нь бид.

Мөнхбаатар дарга үг хэллээ. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн алга байна. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууж, үг хэлнэ ээ.

Ц.Даваасүрэн: Миний хувьд бол цэцийн дүгнэлтийг үндэслэлтэй юм болов уу гэж ингэж бодоод байгаа юм. Тэгэхээр иргэн хүний сонгох сонгогдох эрх бол чөлөөтэй байх ёстой. Тэр хүмүүс дундаасаа нэг ч хүнийг сонгосон болно. Гэтэл тэр хүний дутуу сонголоо гээд сонгосон эрхийг нь хүчингүй болгочхож байгаа нь өөрөө Үндсэн хуулийн зөрчилтэй болчихож байгаа юм.

Тийм учраас зүгээр энэ дээр нэг л айдас байдаг юм. Тэр нь өөрөө хууль бус үйлдэл байхгүй юу. Нэр дэвшиж байгаа хүмүүс яадаг вэ гэхээр надыг дугуйлаарай бусдыг хэрэггүй гэдэг. Энэ л асуудал байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ чинь өөрөө хууль бус үйлдэл учраас энийг тэр хууль бус зохицуулалтаар нь л явах ёстой. Эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ үү, Сонгуулийн хуулийн дагуу буцаад татна уу. Энэ дээр нь л хатуу хандаад явах ёстой. Тэрнээс биш хүний сонгох эрхийг хүндэтгэх ёстой. Хүн татгалзах эрхтэй байх ёстой.

Тийм учраас Хууль бус үйлдлийн төлөө бид нар хүчээр чи заавал сонго, дугуйл хууль гээд байж болохгүй шүү дээ.

Тэгэхээр энэ асуудал дээр бид нар бас нэлээн ул суурьтай хандах ёстой байх. Ер нь цаашдаа бид нар энэ цэц дээр нэг юмыг анхаарахгүй бол болохгүй ээ. Цэц Үндсэн хуулийн зөрчилтэй эсэхийг хянаж байгаа юм. Тэгэхэд тэнд Үндсэн хууль баталж байсан нэг ч хүн байхгүй. Олон жил парламентад сууж байсан нэг ч хүн байхгүй. Аливаа хууль гарахдаа янз бүрийн хэлэлцүүлгийн шатад тэр хууль яаж хэлэлцэгдэж байсан гэдэг тэр түүхийг сонирхох хэрэгтэй юм. Тэр протоколуудыг авч үзэх хэрэгтэй. Тэгснээр бүх юм бүрэн хангагдчихгүй. Ер нь бид нар нэг юмыг ерөөсөө ойлгохгүй байна шүү дээ. Туршлага гэдэг юмыг ерөөсөө үгүйсгээд байгаа юм байхгүй. Ажлын туршлага гэдэг юмыг залуу л байвал гоё гэж үгүй. Шийдвэр гаргах түвшинд бэлтгэхийн тулд хүн туршлагатай болсон байх ёстой. Өнгөрсөн одоо цаг үеэ сайн мэдэж байж ирээдүйг зөв тодорхойлдог. 3 цагт амьдардаг.

Тийм учраас бусад улс орон чинь энэ ажлын туршлага гэдэг юманд илүү ач холбогдол өгөөд байгаа шүү дээ. Би цаашдаа Цэцийг ер нь бүрдүүлэхдээ тэдний бүрэлдэхүүнд адаглаад 3-ны 1 нь Их Хуралд суучихсан, хууль гаргах түвшинд

тодорхой энэ хэлэлцүүлгүүдийн түүхийг мэддэг туршлагатай ийм хүмүүс байгаасай гэж. Одоо ч гэсэн Үндсэн хууль баталж явсан улсууд амьд сэрүүн байж л байна шүү дээ. Тэгэхэд бид нар тэд нарыгаа настай гээд ингээд гудамжинд хаячхаж байна шүү дээ. Уг нь тэд нар нь суугаад тэд нар нь тэр Үндсэн хуулийн агуулгыг хэлэлцэж байсан тэр түүхээ яриад ингээд шийдвэрээ гаргадаг байх ёстой шүү дээ.

Тийм учраас ийм талаас нь бид нар Үндсэн хуулийн цэцээ бэхжүүлэх чиглэл рүү анхаарч явах ёстой зүгээр. Энэ удаагийн дүгнэлтийг бол би Үндсэн хуулийн агуулгатай нийцэж байна гэж үзэж байгаа. Хүн чөлөөтэй сонголт хийх эрхтэй. Тулгуулах тийм зүйл Үндсэн хуульд байхгүй. Хүний сонгосон саналыг хүчингүй болгох эрх байж болохгүй. Хүний сонголтыг нэгийг сонгосон байна.

Тийм учраас би энэ дээр анхааралтай хандаач л гэж бодож байгаа юм.

Д.Амарбаясгалан: Тэгээд Даваасүрэн гишүүн маш чухал ийм зарчмын асуудал хөндөж байгаа юм. Яах вэ Даваасүрэн гишүүн мэдэж байгаа байх 2012 онд энэ олон мандаттай тойрог анх бий болоод тэгээд яагаад мандатын тоогоор дугуйлна гэдэг асуудал Сонгуулийн хуульд орж эхэлсэн бэ гэдэг асуудал энэ дүгнэлттэй холбоотойгоор судлагдсан юм байна лээ. Тэгээд тухайн үед гарсан бодитой эрсдэл нь юу юм гэхээр дутуу дугуйлсан саналын хуудсыг гүйцээж дугуйлдаг хууль бус үйлдлүүд бол их газар авах нөхцөлтэй болсон учраас мандатын тоогоор гүйцээж дугуйлна гэдэг энэ хуулийн заалт энэ Сонгуулийн хуульд орсон юм байна лээ. Одоо ч бас яг тэр нөхцөлөөсөө бид бүрэн ангижраагүй байгаа юм.

Хэдийгээр машинаар саналын хуудсыг тоолж байгаа ч гэсэн баталгаажуулалтын тооллогыг бүгдийг нь гар аргаар 100 хувь хийдэг болчихсон байж байгаа юм. Тэгэхээр нөгөө дутуу дугуйлчихсан саналын хуудсан дээр нэмэлт дугуйлалт хийх тэмдэглэгээ хийх нөхцөл үүсээд ахиад энийгээ нөгөө засаж хянаж чадахгүй хэлбэр рүү Монголын төр орох вий дээ.

Нөгөө сонгуулийн тойрог хэсгийн хороон дээр нэмж дугуйлдаг саналын хуудас машинаар тоолсон, гараар тоолсон тоо зөрдөг гээд ийм хямрал руу оруулах нөхцөл үүсэх вий дээ гэдэг болгоомжлолыг энэ судлаачид бидэнд сануулж хэлж байна лээ. Тэгэхээр энэ санал, дүгнэлтдээ яалт ч үгүй л тал талаас нь бид харах ёстой зүйл гэдэгтэй санал нэг байгаад байгаа юм.

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууж үг хэлье.

Х.Баасанжаргал: Би өөрийнхөө байр суурийг илэрхийлье. Тэгэхдээ миний байр суурь хуульч хүний хувьд энэ хуулийн салбарт 20 жил ажиллаж байгаа хүний хувьд Үндсэн хуульд үнэнч байх тангараг хуульчид өргөдөг. Тийм учраас би өнөөдрийнхөө байр суурь би улс төрийн гэхээс илүү хуульч хүнийхээ хувьд бол энэ өнөөдрийн байр суурийг илэрхийлэх нь зөв байх гэж бодож байр сууриа илэрхийлж байна аа.

3 үндэслэлээр би Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг би хүлээж авах ёстой гэж харж байгаа. 1 дүгээрт бид нарын маргааны гол үндэслэл болоод байгаа энэ хүний сонгох сонгогдох эрхийн асуудал мөн үү гэвэл мөн. Дээрээс нь хамгийн гол нь хуулиар бид нар хүний сонгох сонгогдох эрхийг хязгаарлаж байгаа явдал нь өөрөө Үндсэн хуулийн зөрчил.

Хүний үндсэн эрхийг хязгаарлах тохиолдолд хамгийн бага түвшинд хамгийн зохион байгуулалттай түвшинд хязгаарлах ийм боломжтой бүх боломжийг ашиглах ёстой гэдэг Үндсэн хуулийн үзэл санаа байгаад байгаа юм. Гэтэл бид нар хүний энэ эрхийг хязгаарлахдаа зохион байгуулалтын хувьд янз бүрийн асуудал гарч магадгүй ээ. Улс төрийн шинжлэх ухааны хувьд ийм ийм асуудал гарч магадгүй гэдэг энэ үндэслэлүүд нь өөрөө хангалттай хэмжээнд энэ хүний үндсэн эрхийг хязгаарлах үндэслэл бол би хувьдаа болж чадахгүй байна гэж үзэж байгаа гэсэн үг.

Хоёрдугаарт түүхчилсэн судалгааг судлаачид хийдэг. Заавал тухайн цаг үед амьдарч байсан, 1992 онд Үндсэн хууль баталж байсан хүмүүсээс байж байж л асуудлыг шийдэх гэдэг бол өөрөө их хэт өрөөсгөл явцуу. Судлаачдын арга барилууд, судалгааны арга зүй дээр бол энэ түүхчилсэн судалгааг зайлшгүй хийдэг. Тийм ч учраас бүх Улсын Их Хурлын гишүүдэд 92 оны Үндсэн хуулийн тэмдэглэлийг бүгдэд нь тарааж өгсөн байх. Энэ бол бас их утга уч учиртай гэж би хувьдаа харж байгаа. Бид нар бүгдээрээ түүхчилсэн судалгаагаа давхар хийж байх ёстой.

Тэгэхээр бол бид нар ийм шинжлэх ухааны түвшний судалгааны энэ зарим зүйлүүд дээр бас хүлээн зөвшөөрч хандах ёстой болов уу гэж харж байгаа юм.

3 дугаарт улс төрийн шинжлэх ухааны хувьд бөгөөд улс төрийн намын төлөвшил сонголтын тухайд ийм үндэслэлүүд нэлээн гарч ирж байх шиг байна. Гэхдээ яг харамсалтай нь бид нарын гар дээр Улсын Их Хурлын гишүүдийн хувьд бол гишүүдэд яг энэ улс төрийн шинжлэх ухаан талаасаа энэ Цэцийн шийдвэр ийм ийм үндэслэлээр болохгүй байгаа юм гэдэг яг ийм судалгааны баримтууд хараахан ирээгүй байна. Би бас өөрийнхөө хэмжээгээр зүгээр интернэтээс л хайсан. Өөр газраас би хайж үнэхээр амжсангүй. Тэгэхээр улс төрийн тал, шинжлэх ухаан талаасаа бас ямар гарц гаргалгаа, ямар үндэслэл байдаг юм вэ гэдгийг мэдээж хайж олж, уншиж судлах гэж оролдсон.

Тэгэхээр энэ 3 үндэслэлээр би бол Цэцийн дүгнэлтийг бол манай Улсын Их хурал хүлээж авах ёстой гэж харж байгаа. Тэгэхээр Үндсэн хуульдаа ямагт үнэнч байх ийм тангаргаа бол санаж байх үүрэгтэй хүний хувьд бол би өнөөдрийн энэ байр сууриа илэрхийллээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Бадрахын Найдалаа гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Найдалаа: ҮХЦ-ийн дүгнэлт яах аргагүй зөв гэж үзэж байна аа. Тэгээд яах вэ бид нар ингээд Үндсэн хуулийн заалт зүйл, хүний эрх тойроод жоохон хүнд үгээр яриад байх шиг байна. Иргэд бас илүү сайн ойлгоосой гэж бодож байна. Маш хялбархан хэлэх юм бол сонгогч иргэн 10 хүнийг арвууланг нь дугуйлахгүй бол таны саналын хуудас хүчингүй болно оо. Таны санал тэр чигтээ хүчингүй болно оо гэдгийг Үндсэн хууль зөрчсөн л гэж байгаа юм. Хүн нэг хүнийг сонгомоор байж болно шүү дээ. 2 хүнийг сонгомоор байж болно. Бусад нь сонгомооргүй эсрэг саналтай байж болно. Тэр сонгогчийн тэр иргэний эрх яагаад хаагдаж байгаа юм. Яагаад заавал 10 хүнийг сонгох ёстой юм. Тэр байтугай нэг намаас нь 10-ыг дугуйлна шүү гээд явж байсан тохиолдол байдаг шүү дээ. Иргэн 3 хүнийг нь сонгоод үлдсэн 7-г нь сонгомооргүй байж болно шүү дээ. Энийг яагаад хязгаарлаад байгаа юм бэ гэж ингэж хязгаарлаж байгаа нь буруу гэсэн дүгнэлт ҮХЦ өгсөн байна. Тэгээд энийг бол дэмжиж байгаа юм. Тэгээд ер нь зүгээр энэ дээр бол нарийн хууль мууль ярихаасаа өмнө зүгээр энгийн дарааллаар бодохоор тийм байгаа биз дээ? Тэгээд иргэд энийг ойлгоосой гэж бодож байна. Гишүүд энэ дээр хэрвээ янз янзын тайлбар хэлээд

сонгогч хүн заавал 10-ыг дугуйлах ёстой нэг л дутуу дугуйлбал таны бүх сонголт санал эрх чинь хүчингүй болно гэж үзэж байгааг дэмжиж байгаа гишүүдийг би ойлгохгүй байна.

Ямар ч тайлбар байсан энэ зөндөө л ярьж байна л даа. Ямар ч үндэслэлгүй байна. Сайн ярих юм бол яг иргэдийн Монголын улс төрийн цаашдын зөв хөгжил, ардчиллын хөгжил биш зөвхөн намын эрх ашиг өөрийнхөө сонгогдох эрхийг л бодож байна гэж би итгэж байна. Тэгээд энийг Үндсэн хуулийн цэцийн энэ дүгнэлтийг хүлээж авахгүй эсэргүүцэж байгаа гишүүдийг бол би тэгж л ойлгоно. Тэгээд иргэд ч гэсэн ингэж ойлгоосой гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн үг хэлье.

Б.Батбаатар: Улс төрийн сонгуулийн гарч байгаа үр дүн тоо талаас нь ярих юм бол 10 мандаттай тойрогт арвууланг нь сонгоно уу гэдэг нь Ардын нам, АН 2-т л ашигтай заалт л даа. Гэхдээ өнөөдөр бид нар хуулийнх нь талаас сонгуулийн үр дүн талаас нь бусад энэ хүлээн зөвшөөрөгдөх байдлаас нь хараад үзэхээр бид нар энэ Цэцийн дүгнэлтийг хүлээж авмааргүй байгаа юм.

Их Хурлын 126 гишүүнийг сонгохгүй гэж хэлж байгаатай адилхан шүү дээ. Их Хурал 76-тай байх ёстой гээд. Энэ сонгох эрхийг минь зөрчөөд байна. Ийм 126-уулаа байж болохгүй гээд тоог нь хасах тухай ярьж болно шүү дээ. Их Хурал аравхан гишүүнтэй байж болно гэж ярьж болно, нэгд.

Хоёрт томсгосон тойргоо байхгүй болгох тухай асуудал энийг дагаад явна. 10 мандаттай баруун 4 аймаг гэхэд Говь-Алтай хорин хэдэн мянган сонгогчтой. Тэр 10 мандатад сонгогдсон хүнээс Завханаас нэг л хүн сонгогдсон шүү дээ. Завхан аймгийн. Ховд, Увс нь илүү олон сонгогчидтой. Аймгаараа хуваагдах аль нам нь байх нь хамаагүй тухайн аймгийн хүмүүсээ сонгож байх энэ чиглэл рүүгээ ороод эхэлбэл яах юм бэ.

Ингээд нөгөө сонгуулийн үр дүн нь юу болж байна вэ гэхээр аймаг, орон нутаг, нам дотроо хуваагдах нөгөө томсгосон тойрог, бүсчилсэн хөгжлийн үндсэн зарчим нь алдагдах энэ чиглэл рүүгээ яваад олон жижиг хуваагддаг энэ чиглэл рүүгээ яваад эхлэх юм байгаа юм аа. Тэгэхээр улс төрийн ашиг сонирхол талаасаа биш гишүүд маань ярихдаа бол хууль ярьж байна, улс төр ярьж байна. Сонгогчийн эрх ярьж байна. Сонгогдох хүмүүсийн эрхийн тухай асуудлыг ярьж байна. Энэ нэгийг сонгоорой гэдэг юм чинь зүгээр л гарцаагүй явна шүү дээ. Энэ цэцийн дүгнэлтийг хүлээж авбал яаж хуваагдах юм. Уул нь зүгээр одоо дараагийн 2028 оны Их Хурлын сонгууль боллоо гэхэд 10 хүртэл буюу нэгийг ч сонгож болно гэдэг заалт нь улс төрийн ашгаа бодвол Цэцийн дүгнэлтийг дэмжмээр байгаад байгаа юм. Тэгэхдээ улс төрийн ашиг биш үндэсний ашиг сонирхол хуваагдалгүй нэгдмэл улс бид нар чинь холбооны улс биш байхгүй юу. Холбоо болгон нь тусдаа хуультай байдаг тийм холбооны шинж чанартай улс биш.

Тэгэхээр нэгдмэл улсынхаа үндэснээс Үндсэн хууль дээр 126 гишүүнтэйгээр Их Хурал байна гээд заачихсан байгаа шүү дээ. 126-г сонгохгүй ээ. Миний сонгох эрх. Би энэ 3 хүнийг л сонгомоор байна гээд Их Хурал 3 хүнтэй л байх ёстой гээд байвал бас нэг болохгүй тийшээгээ л явна шүү дээ. Тэгэхээр энэ талаасаа бодоод бид нар цэцийн дүгнэлтийг хүлээж авах нь тийм зөв биш байх л гэж байр сууриа илэрхийлж байна.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Харин тийм. Батбаатар гишүүний болгоомжилж байгаа зөв л дөө. Одоо тэгээд аль ч тойрог дээрээс хамгийн их мөнгөтэй хүн нь сонгогддог болох нь байна шүү дээ. Мөнгөтэй нэгхэн хүнийг сонгодог тийм тогтолцоо руу энэ Цэцийн дүгнэлт аваачиж өгөх гэж байна гэсэн үг болчихож байгаа юм. Тэгэхээр энийг бол их сайн бодож хүлээж авах авахгүйтэй холбоотой асуудлаар мэргэжлийн эрдэмтэд, судлаачид цаашлаад сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулдаг Сонгуулийн хорооны санал, дүгнэлтийг ер нь улс төрийн намын бүлгүүд дахиж ярьж сонсох нь зүйтэй байх гэж бодож байгаа юм.

Өнөөдөр бид бүрэн мэдээлэлгүй байгаа. Даваасүрэн гишүүн түрүүн бас хэллээ шүү дээ. Энэ хуулиуд ямар цаг хугацаанд яаж батлагдаж явж байсан түүх, тухайн цаг үеүдийн нөхцөл байдлын талаар ч бас түүхчилсэн судалгааг их сайн хийж дүгнэлттэй танилцаж байж энэ шийдвэр гаргах нь зөв юм гэсэн ийм байр суурийг хэлж байна аа.

Тэгэхээр гишүүд ч гэсэн энэ дээр олон талаас нь харж дүгнэлтээ гаргах тэр боломж нөхцөлийг олгох нь зүйтэй байх гэсэн ийм бодолтой байна. Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа.

Санал хураалтыг хойшлуулна, дараагийн 7 хоног руу.

Энэ дээр улс төрийн намууд энэ дээр олон талаасаа ярилцах шаардлагатай байгаа нь гишүүдийн асуулт асууж, үг хэлж байгаа байр сууриас харагдаж байгаа учраас бид энэ асуудал дээр хөнгөн хуумгай хандаж болохгүй гэж ингэж бодож байна аа. Хүлээж авбал нэгдсэн байр суурьтай, авахгүй бол нэгдсэн байр суурьтай байх нь зөв өө гэж бодож байна. Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

12.47 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА